

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ “2021-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ” –НИЙ 2021-2024 ОНЫ БИЕЛЭЛТ

№	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Биелэлт
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО						
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: Нэг. Хууль зүйн нэгдсэн бодлого						
Зорилт 1.Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.						
1.1.	Хууль хоорондын уялдааг нэгдсэн бодлогоор хангах зорилгоор нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Хамтран боловсруулсан хуулийн төслийн тоо	0	2	Улсын төсөв Бусад эх үүсвэр	Төрийн захиргааны төв болон захиргааны 21 байгууллагатай хамтран нийтлэг харилцааг зохицуулсан 2023 онд 68, 2024 онд 64, нийт 132 хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Мөн хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан холбогдох ажлын хэсгээс мэргэжил, арга зүйн туслалцааг тухай бүр өгч, хамтран ажилласан.
1.2.	Хууль зүйн бодлогын судалгаа хийх, хуулийн хэрэгжилтийг үнэлэх.	Судалгааны болон үнэлгээний тайлан	0	1	Улсын төсөв	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, Арилжааны тухай хуулийн төслийн, Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежменийн тухай хуулийн төслийн, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай

						хуулийн шинэчилсэн найруулгын, Төрийн аудитын тухай хуулийн, Иргэний хуулийн “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” болон Авлигын эсрэг хуулийн зарим зохицуулалтад, Авлигын багц хуулийн харьцуулсан Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслүүд, түүний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ, судалгаануудыг хөндлөнгийн судлаачаар тус тус хийлгэсэн.
1.3.	Хууль тогтоомжийг сурталчлах, хүртээмжийг нэмэгдүүлэх.	Иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг тухай бүр нь сурталчилсан эсэх	0	1	Улсын төсөв	Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Улсын Их Хуралд өргөн барьсан болон боловсруулж буй хууль тогтоомжтой холбоотой цаг үе, үйл явдлын талаарх мэдээ мэдээлэл, богино хэмжээний видео (reel), постер, шууд дамжуулалт зэрэг контентуудыг бэлтгэн давхардсан тоогоор 2022 онд 230, 2023 онд 247, 2024 онд 334 хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчилж ажиллалаа.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
1.4.	Захиргааны хэм хэмжээний актын бүртгэл хяналтын тайлангийн цахим системийг боловсруулах	Цахим сантай болсон эсэх	0	1	Улсын төсөв	Тус ажил тодорхойгүй шалтгаанаар зогссон бөгөөд 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
Хоёр. Олон улсын гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого						
Зорилт 1. Сайдын эрхлэх асуулын хүрээнд олон улсын гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.						
1.1.	Гадаад орнуудтай эрүү, иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн орчныг өргөжүүлэн хөгжүүлэх	Олон талт болон хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж	36	41	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Европын зөвлөлийн “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенц”-ыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар соёрхон батлуулав.

		Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				“Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын конвенц”-д нэгдэн орох тухай саналаа 2019 онд Европын зөвлөлд хүргүүлсэн боловч уг зөвлөлийн Сайд нарын хороо манай улсын энэхүү хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан хариуг өгсөн. “Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээ”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээ”, “Иргэний ба арилжааны хэргийн талаар эрх зүйн болон шүүхийн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийг тус тус Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар соёрхон батлуулахаар ажиллаж байна.
1.2.	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Монгол Улс нэгдэн орсон хүний эрхийн чиглэлээрх конвенцид заасан Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаа хийх	Судалгааны тайланг хэлэлцүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 09 дүгээр тогтоолоор Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгээс санал, дүгнэлтээ хүргүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 24 дүгээр тогтоол гарсны дагуу Засгийн газраас хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
1.3.	Засгийн газарт холбогдох олон улсын арбитрын маргаанд Засгийн газрыг	Арбитрын маргаан хариуцсан нэгж	0	1	Улсын төсөв,	"Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон

	төлөөлж оролцох зохион байгуулалтын бүтцийн нэгжийг бий болгох	байгуулагдсан эсэх			Бусад эх үүсвэр	тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолын 2.2 дахь заалтын "Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газар" гэсний дараа "(Олон улсын арбитрын хэлтэстэй)" гэж нэмсүгэй" гэж өөрчлөлт оруулснаар Олон улсын арбитрын хэлтэс нь бүтцийн хувьд дарга, шинжээч, хоёр мэргэжилтний орон тоотойгоор бие даасан нэгж болж батлагдсан.
1.4.	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх	Арга хэмжээ зохион байгуулсан эсэх, баримт бичиг байгуулсан эсэх	0	4	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Сайдын эрхлэх асуудлын хүрээний хоёр талт болон олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, уялдуулан зохицуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 онд 13, 2023 онд 3, 2024 онд 14, Дэд сайдын 32, Төрийн нарийн бичгийн даргын 14 айлчлал болон дотоодын 84 уулзалтын арга хэмжээг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус яамнаас харьяа агентлаг, байгууллагуудын гадаад улсын ижил түвшний байгууллагатай байгуулах санамж бичиг, гэрээг хянаж Гадаад харилцааны яамнаас 2023 онд 17, 2024 онд 14 зөвшөөрлийг авсан. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хессен муж улсын Хууль зүйн яам болон Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын, "Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хууль зүйн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг", "Кибер аюулгүй байдал, кибер орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэх тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Бүгд Найрамдах

						Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын хамтын ажиллагааны гэрээ”, “Хууль зүйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хууль зүйн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”, “Хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Баварийн Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” зэргийг байгуулав. "Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын дүрэм"-ийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 150 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрч гишүүнээр элссэн. Мөн Монгол Улс Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэн("UNIDROIT")-д гишүүнээр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр гишүүнээр элссэн бөгөөд тус байгууллагын дүрмийг батлах тухай асуудлыг Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан.
1.5.	Олон улсын байгууллагын болон гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн төсөл, хөтөлбөрийн санал хүргүүлэх, хэрэгжүүлэх, уялдааг хангах	Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдааг хангаж, Сангийн яам болон холбогдох олон улсын	7	9	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Бүгд Найрамдах Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Эрх зүйн шинэтгэл багц төсөл"-ийн хүрээнд “Хууль сахиулахын их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт” бүхий 2,0 сая ам.долларын тоног төхөөрөмжийг Дотоод хэргийн их сургуульд хүлээлгэж өгсөн ба төсөл хэрэгжиж дууссан эцсийн тайланг Эксим банк, холбогдох байгууллагуудад, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн "Эрх зүйн шинэтгэл багц

		байгууллага, гадаад улсаас санал, зөвшөөрөл авсан эсэх				төсөл"-ийн хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Мөн “Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)” (18.5 сая ам.доллар): Зээлийн хэлэлцээрийг 2021 онд зохион байгуулж, 2023 онд зөвлөх үйлчилгээ үзүүлэх 3,212,000 ам.долларын гэрээ байгуулсан. Тус төслийг хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо, санхүүжилтийн саналыг тусгаж төслийн нэгжийн бүрэлдэхүүн батлуулах тухай хүсэлтийг 2024 оны 1/2522 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл”: Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын ЭЗХХАС-ын хоорондын (МОН-16) тоот Зээлийн гэрээний дагуу хэрэгжиж дууссан. “Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөл”-ийг 2023 онд, мөн “Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх” төслийн нээлтийг 2024 оны 05 дугаар сард тус тус хийв. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Яамны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2024-2027 онд хэрэгжүүлэх “Just transition” эрх зүйн зөвлөгөө өгөх ба шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхыг сайжруулах” төслийг эхлүүлсэн.
--	--	--	--	--	--	--

						Дээрх төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, санал солилцох чиглэлээр хэд хэдэн удаагийн хурал, уулзалтын арга хэмжээг зохион байгуулав.
Гурав. Эрх зүйн шинэтгэлийн бодлого						
Зорилт 1. Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.						
1.1.	Орон тооны гишүүдээс бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог байгуулах замаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлж, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	5	Улсын төсөв	Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Шүүх байгуулах тухай хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус батлагдсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох судалгааг хийн хуулийн төслийг боловсруулж байна.
1.2.	Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулж, бизнес эрхлэх таатай орчныг дэмжсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Анхдагч хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	11	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд 2021 оны 05 дугаар сарын 06 -ны өдөр эцэслэн батлагдсан. Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн, Арилжааны хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, түүнийг дагаж гарах хуулийн төслүүд, тэдгээрийн товч, дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийсэн.

						Энэ хүрээнд Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны “Монгол Улсад арилжааны шүүхийн шийдвэрийн биелэлтийг бэхжүүлэх нь” техникийн туслалцааны төслийн хамтын ажиллагааны хүрээнд “Иргэний болон арилжааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх олон улсын шилдэг туршлага” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Эвлэрүүлэн зуучлалын тухай, Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийж, төслийн эхний хувилбарыг боловсруулан ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/376 дугаар тушаалаар байгуулагдсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2024 онд 2 удаа хуралдсан. Мөн Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын Хуульчдын холбоотой хамтран Компанийн тухай хууль, Арилжааны хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2024 оны 02 дугаар сард тус тус зохион байгуулсан.
1.3.	Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх-	Анхдагч хуулийн төсөл, хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн	0	2	Улсын төсөв	Хуулийн төслийг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ба Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. Хууль зүйн байнгын хороотой хамтран тус хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион

		төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				байгуулав. Мөн тус хуулийн төслийг боловсруулах ажлын дэд хэсэг 2022 оны 05 дугаар сарын 10, 05 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус тус хуралдсан.
1.4.	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгох замаар эрх зүйн орчныг сайжруулах	Хуулийн шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	8	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 22 -ны өдөр эцэслэн баталсан.
1.5.	Үндсэн хуулийн цэц болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	2	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2024 оны 1/327 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. Хуулийн төслийг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 5 хоногийн завсарлага авсан.
1.6.	“Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөрийг боловсруулах	“Эрх зүйн шинэтгэл II” хөтөлбөрийн төслийг боловсруулж	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр II”-ийг боловсруулах ажлын хэсгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн

		Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				үзэл баримтлалыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан, хуулийн төслийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Тус газраас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот хөтөлбөр болох Засаглалын зорилтот хөтөлбөрт тусгасан байх тул хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэсэн хариу ирүүлсэн. Иймд уг асуудлыг “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хамт Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тул тусдаа бие даасан хөтөлбөр гаргах шаардлагагүй болсон.
1.7.	Хууль зүйн туслалцаа авах хүрээг өргөжүүлэх замаар хууль зүйн туслалцааны эрх зүйн орчныг сайжруулах	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Хуулийн төслийг боловсруулж, өргөн барьсныг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.8.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулах	Шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг хийж, төслийг боловсруулан

		Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				холбогдох яамд, байгууллагуудаас санал авахаар хүргүүлсэн.
1.9.	Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ хязгаарыг тодорхой болгох, Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгох	Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр эцэслэн батлагдсан.
1.10.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Төрийн өмчит болон төрийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 06 дугаар сарын 09 -ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. Мөн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хурлыг 2024 онд 3, хэлэлцүүлгийг 1 удаа тус тус зохион байгуулсан.
1.11.	Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	7	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан бичгийн дагуу тус ажлын албанд 2019 оны 1-1/1437 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн тус зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах албан хаагчийн нэрийг хүргүүлсэн.
1.12.	Архидан согтуурахтай хийх тэмцлийг	Хуулийн шинэчилсэн найруулгын	0	1	Улсын төсөв	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 07 дугаар

	эрчимжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах	төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх				сарын 05 -ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.13.	Цахим шинэчлэлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах	Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	3	Улсын төсөв	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
1.14.	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах	Шинэчилсэн найруулгын болон хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	0	8	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлтийн төслийг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.
Дөрөв. Хууль зүйн туслалцаа						
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
1.1	Төрөөс иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж хүний эрх, эрх чөлөөг хангах стандартад нийцсан ажлын байр, орчин бүрдүүлэх	Салбарын тоо	1	8	Улсын төсөв	Хууль зүйн туслалцааны төвийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, үйлчлүүлэгчийн хувь хүний нууц, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай орчин нөхцөлөөр хангуулах зорилгоор 2022 онд Монгол Улсын 21 аймгийн 11 салбарын ажлын байрны нөхцөлийг сайжруулсан. Мөн Өвөрхангай аймгийн Хар

						хорин сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, нийт 3 салбарыг шинээр байгуулсан.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	Иргэнд хүртээмжтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн цахим үйлчилгээ нэвтрүүлэх	Ухаалаг утас, мессеж, бүртгэлийн болон хууль зүйн туслалцааны программын тоо	0	3	Улсын төсөв	Төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчийн хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг “E-Mongolia” системээр дамжуулан шууд хүлээн авах боломжтой болсон. Мөн төрийн байгууллагын мэдээлэл солилцооны “Хур” системд холбогдох ажил бүрэн дууссан. Ингэснээр тус системээс улсын өмгөөлөгчид цаг алдалгүй үйлчлүүлэгчийн өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь амьжиргааны түвшний мэдээллийг шүүх нөхцөл бүрдсэн.
Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.						
3.1	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн ажилд дэмжлэг үзүүлэх урт хугацааны төсөл хэрэгжүүлэх	Төсөл хэрэгжсэн эсэх	0	1	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Азийн хөгжлийн банкны техник туслалцааны дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж буй “ТТ-10014 МОН:Хууль зүйн салбарын эрх зүй, мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 5 багц /G14-G18/ нийт 539,233,340 төгрөгийн өртөг бүхий сервер, сторез, ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер, принтер, сканер, хяналтын камер зэргийг хүлээн авч, улсын өмгөөлөгч нарт зөөврийн компьютер, салбар бүрийг принтерээр хангаж байна. Мөн тус төвийн цахим хуудас /www.lac.gov.mn/-ыг шинээр хийлгэж, мэдээллийг байршуулан ашиглаж байна.
Тав. Иргэний, хуулийн этгээдийн , эд хөрөнгйн эрхийн улсын бүртгэл болон бусад бүртгэл						
Зорилт 1. Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.						
1.1.	Улсын бүртгэлийн үйлчилгээний	Иргэний бүртгэлийн	0	1	Улсын төсөв	Иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг регистрийн дугаарын оронд ил харагдах

	цахимжуулалтыг эрчимжүүлэх	дугаарыг хэрэглээнд нэвтрүүлсэн эсэх				байдлаар оруулж, шинэчилсэн загварын иргэний үнэмлэхэд бичилт хийх ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 494100 иргэнд шинэчилсэн иргэний үнэмлэхийг олгосон байна. Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) системээр дамжуулан төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. Мөн Монгол Улсад төрсөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар харьяат болсон иргэний улсын бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтөлж, тухай бүр мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаар шууд олгогдож, иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хөтөлсөн тохиолдолд тухайн иргэний бүртгэлийн дугаарыг мэдээллийн сангаас сэргээж, ашиглах боломжтой болсон. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаяг нээн, Сонгуулийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж, сонгогчдын нэрийн жагсаалт болон сонгогчийн ирц бүртгэлийн программд сонгогчийн иргэний бүртгэлийн дугаарыг оруулсан.
		Тоон гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оноос Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэддээ тоон гарын үсгийг 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр тоон гарын үсгийг олгож эхэлсэн

						бөгөөд иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, КИОСК машинаар, мөн гар утасны аппликэйшнаар 2024 оны байдлаар нийт 1439716 иргэнд тоон гарын үсэг олгосон. Монгол Улсын 51 Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан тус улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эхлүүлсэн ба хүсэлт гаргасан нийт 244 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Иргэдэд тоон гарын үсэг олгосноор төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia.mn/-д нэвтэрч, төрийн байгууллагын бусад үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн.
		Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг нэвтрүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	“E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системээр улсын бүртгэлийн 12 төрлийн үйлчилгээ үзүүлж байсан бол өргөжүүлэн “E-Business” цахим порталаар 7 төрлийн лавлагаа, гэрчилгээ олгох үйлчилгээг үзүүлж эхлээд байна. 2024 онд нийт 652 цахим гэрчилгээ олгох хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэсэн.
Зорилт 2. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг хөгжүүлнэ.						
2.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийг үе шаттайгаар архив, үйлчилгээний байртай болгох	Ашиглалтад орсон архив, үйлчилгээний байрын тоо	5	15	Улсын төсөв	Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 938 м/кв зоорьтой дөрвөн давхар 2,519,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг 2023 онд, Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн 1.333,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг мөн 2023 онд, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг 2024 онд ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газрын 2023 оны 109 дугаар тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд

						бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 104, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 75 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байрны 580,2 м² талбай бүхий хэсгийг Улсын бүртгэлийн хэлтсийн мэдэлд эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн. Мөн Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын хуучин 507.94 мкв байрыг балансаас баланст тусган Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэж 2023 онд үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомж, зохих журмын дагуу сонгон шалгаруулж, 2,534,800.000 төгрөгийн төсөвт өртгөөр санхүүжүүлэхийг тохиролцон, 2024 оны 12 дугаар сарын 26-нд гэрээ байгуулж, баталгаажуулсан.
2.2.	Үндэсний баримт бичгийн бичилтийг үйлдвэрийг байгуулах	Үйлдвэрийн тоо	1	2	Улсын төсөв	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай” н/155 дугаар тогтоолоор батлагдсан загвар, тодорхойлолтын хэрэгжилтийг тус тус ханган Хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсэн.

						2022-2024 оны байдлаар энгийн гадаад паспорт 327199, цахим гадаад паспорт 65895, нийт 986151 иргэнд олгосон байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт загварыг шинэчлэн батлах тухай” 374 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулан 2024 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 52 дугаар тогтоолоор батлуулсан. Иргэний үнэмлэхийн бичилтийн үйлдвэрт 21 аймгийн 35442, нийслэлийн 9 дүүрэг, үйлчилгээний нэгдсэн төв, нэг цэгийн үйлчилгээгээр 188053, e-mongolia-аар 32914, Элчин сайдын ямаар дамжуулан ирсэн 5951, нийт 227270 иргэний цахим үнэмлэхийг хэвлэж хүргүүлсэн.
2.3.	Мэдээллийн сангийн нөөцлөлтийг автомат горимоор хийх, мэдээллийн санг хянах программ хангамж боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх	Хэрэглээнд нэвтрүүлсэн программ хангамжийн тоо	0	1	Улсын төсөв	Нөөцлөлтийг 2 төрлөөр хийж байна. Үүнд: a.Oracle Database Physical Active Dataguard буюу Real Time нөөцлөлт хийж байна. b.Өдөр бүр 23:50 цагт Oracle Data Pump технологийг ашиглаж, Dump файл гаргадаг. <u>Virtual Machine нөөцлөлт:</u> 100 гаруй виртуал машиныг Dell EMC Data Protection болон Veeam Backup and Replication системүүдийг ашиглаж өдөрт 3 удаа 8 цагийн зайтай нөөцлөлт хийж байна. <u>Зургийн файл нөөцлөлт:</u> Иргэн, Хуулийн этгээд, эд хөрөнгө гэх мэт системүүдийн зургийн файл нөөцлөлтийг өдөр болгон 23:50 цагт хийж байна.
2.4.	Бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа сервер, техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх	Шинэчлэгдсэн тоног төхөөрөмжийн хувь	10	100	Улсын төсөв	Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2023 онд Нийслэлийн улсын бүртгэлийн газарт 74,3 сая төгрөгийн анхны үнэтэй 32 нэр төрлийн 72, 36,1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тавилга, эд хогшил, 3 үйлдэлт принтер, зөөврийн

						компьютер, 125,1 сая төгрөгийн үнэ бүхий 6.915 ширхэг бар код уншигч, хурууны хээний скайнэрыг шилжүүлсэн. Нийслэлийн улсын бүртгэлийн газрын 2024 онд шинээр байгуулагдсан 10 төвд 29,6 сая төгрөгийн 10 нэр төрлийн 26 ширхэг тавилга, эд зүйлс болон 97,1 сая төгрөгийн өртөгтэй 36 нэр төрлийн компьютер, 3 үйлдэлт принтер, зөөврийн компьютер зэргийг тус тус шилжүүлсэн. БНСУ-ын Хамтын ажиллагааны байгууллагын тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд нийлүүлж буй суурин компьютер 50, гурван үйлдэлт принтер 25, сканер 25 ширхэгийг хүлээн авч, Улсын бүртгэлийн анхан шатны нэгжүүд болох аймаг, нийслэл сум, дүүрэгт хуваарилалтын дагуу акт үйлдэн хүлээлгэн өгч, хуучин тоног төхөөрөмжийг татан авсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр улсын бүртгэлийн үйл ажиллагаанд 69,8 сая төгрөгийн үнэ бүхий 22 ширхэг компьютер, принтерийн дэмжлэг үзүүлсэн.
2.5.	Сүлжээний нууцлал, аюулгүй байдлыг хангах	Хяналтын систем нэвтрүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-аас буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах хяналтын системийг бүрэн нэвтрүүлсэн.
		Шинэчлэгдсэн тоног төхөөрөмжийн хувь	0	100	Улсын төсөв	
2.6.	Эрчим хүчний нөөцийн эх үүсвэртэй болох	Өөрийн мэдлийн эрчим	0	1	Улсын төсөв	Дизель генератор болон серверийн өрөөний болон бусад агааржуулалтын системийн засвар

		хүчний үүсвэртэй болсон эсэх	эх			үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд цахилгаан хэлбэлзсэн, тасарсан үед дээрх дизель генератор нь автоматаар сэлгэн залгагдаж Мэдээллийн технологийн төв байран дахь серверийн өрөө, бичилтийн үйлдвэрийг эрчим хүчээр хангах юм. Мөн шинээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1-р байрны цаана байрлах цахилгааны дэд станцаас нэмэлт тэжээлийн эх үүсвэр татаж өөрийн эрчим хүчний эх үүсвэртэй болсон. Цахилгаан тасарсан үед нөөц эх үүсвэрээр хангах зорилгоор “Саммит компьютер технологи” ХХК-аар генераторт сервис үйлчилгээг хийж гүйцэтгүүлсэн ба 1 жилийн хугацаатай сервис үйлчилгээ хийх тоног төхөөрөмж, лицензийн худалдан авалтыг хийсэн. Үүнд: •Dell All Flash Unity 380 серверийн хард диск 1 ширхэг, •Dell All Flash Unity 880 серверийн хард диск 1 ширхэг •Dell NX3230серверийн хард диск 6 ширхэг •Dell R740 серверийн хард диск 4 ширхгийг тус тус худалдан авч нөөц бүрдүүлсэн.
Зорилт 3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
3.1.	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх	Цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээний тоо, төрөл	26	30	Улсын төсөв	Ухаалаг засаг төслийн дэмжлэгтэйгээр Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар дамжуулан 29 төрлийн лавлагаа, 94 төрлийн үйлчилгээ /иргэний улсын бүртгэлийн 40, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 54, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 29/-г нийт 123 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн иргэдэд үзүүлж байгаа бөгөөд 2024 онд нийт 18075802 лавлагаа, үйлчилгээг олгосон байна.
3.2.	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн	Хаягийн мэдээллийн	0	100	Улсын төсөв	Хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй

	газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох	нэгдсэн сангийн хэрэглээний хувь				бүртгэлийг нөхөж оруулах ажлын явц 62.7%-тай байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь 2024 онд нийт 4 удаа уулзалт зохион байгуулсан. Уулзалтуудаар газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэхэд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлж, мэдээлэл солилцохоор Үндэсний дата төвд байрлах баазад газрын үйлчилгээний түүхчилсэн мэдээллийн сервисийг үүсгэж, ГЗБГЗЗБГ-аас авах хаягийн мэдээллийн багануудыг тодорхойлж хүргүүлсэн.
3.3.	Улсын архивын бүртгэлийн баримтыг цахимжуулах	Цахимжилтын хувь	85	100	Улсын төсөв	Иргэний улсын бүртгэлийн нийт 146246 бүртгэлийн 444908 хуудас материалыг цахимжуулсан. Үүнд: Төрсний бүртгэлийн 83200 иргэний 207500, Овог нэр өөрчилсний 16420 бүртгэлийн 32810, Үрчлэлтийн бүртгэлийн 1560 иргэний 3120, Гэрлэсний 3905 бүртгэлийн 7870, Гэрлэлт дуусгавар болсны 1130 бүртгэлийн 2513, эцэг эх тогтоосны 8860 бүртгэлийн 17904, иргэний үнэмлэхийн 15645 бүртгэлийн 39112

						хуудас мөн иуб-1,7,21 маягтыг 15526 иргэний 134079 хуудас, эх нотлох баримт бичгийг, нийт 146246 иргэний 444908 хуудас баримтыг цахимжуулаад байна.
Зургаа. Оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал						
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
1.1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж Оюуны өмчийн газрын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан видео санамж, мэдээллийг дохионы хэлээр орчуулан олон нийтэд түгээх	Мэдээллийг дохионы хэлээр орчуулан түгээсэн эсэх	0	1	Улсын төсөв	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	Оюуны өмчийн мэдээллийн сан бүрдүүлж хамгаалах, сурталчлах ажлыг идэвхжүүлэх	Цахим хэлбэрт оруулсан бүтээлийн тоо	12284	90636	Улсын төсөв	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.
Зорилт 3. Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						
3.1.	Эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдсэн орох	Нэгдсэн орсон гэрээ, хэлэлцээрийн тоо	16	17	Улсын төсөв	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.
3.2.	Хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр шинэ төслийн санал боловсруулах, одоо	Хоёр болон олон талт гэрээ, хамтын ажиллагааны санамж бичгийн	3	17	Улсын төсөв	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.

	хэрэгжиж байгаа хамтын ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэх	тоо, дотоод арга хэмжээний тоо				
3.3.	Оюуны өмчийн салбарын оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, технологи, инновацийг дэмжих төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх	Технологи, инновацийг дэмжих төвүүдийн тоо	15	20	Улсын төсөв	Тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан хүртээмжтэй хөгжилд түүжээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
1.1	Олон-нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах	Олон нийтийн цагдаагийн тоо	466	1000	Улсын төсөв	Цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан тухайн жилд ажиллах олон нийтийн цагдаагийн тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэн 2022 онд улсын хэмжээнд 103, 2024 онд 199 орон тоог тус тус нэмэгдүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас хангалтаар нийт 224.3 сая төгрөгийн олгож, цалин урамшууллыг нийслэлд 999.800 төгрөг байсныг 1.000.000 төгрөг, орон нутагт дунджаар 110.000-550.000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Олон нийтийн цагдааг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг барьж 2 жил үр дүнтэй ажилласан 96 олон нийтийн цагдааг цагдаагийн алба хаагчаар дэвшүүлэн томилж, давхардсан тоогоор 233 удаагийн сургалт зохион байгуулж, 551 олон нийтийн цагдааг хамруулах хэлбэрээр ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Мөн Улаанбаатар хотын гудамж замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээ, зогсох зогсоол болон Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7

						дахь хэсэгт заасан зөрчлүүдэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий 524 олон нийтийн цагдааг ажиллуулахтай холбогдон гарах төсвийн тооцооллыг гарган Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 1373 олон нийтийн цагдаагийн орон тоог тогтоолгоод байна.
1.2.	Стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байрыг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулах	Эрүүлжүүлэх, баривчлах байрны тоо	0	2	Улсын төсөв	Улсын хэмжээнд 1966-2021 оны хооронд ашиглалтад орсон 35 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байгаа ба стандарт, шаардлага хангаагүй 10 аймаг, сумын эрүүлжүүлэх, саатуулах байрууд үйл ажиллагаа явуулж байна. Дээрх эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр 2022 онд 9 байранд улсын төсвөөс 10.6 сая, 3 байранд орон нутаг болон бусад төсвөөс 229.7, нийт 240.4 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, гал тогоо, хими цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг шинээр суурилуулж, 2024 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн 1 дүүрэг, Эрүүлжүүлэх, саатуулах төв, 7 аймгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байранд засвар үйлчилгээнд нийт 22.2 сая төгрөгийг зарцуулсан. Архангай аймаг дахь Цагдаагийн газрын барилга, эрүүлжүүлэх, түр саатуулах байрны 2 блокийн барилгыг 5.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2022 онд эхлүүлж, 2024 онд ашиглалтад хүлээн авсан. Мөн Баянхонгор, Дорнод аймгийн цагдаагийн газар эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны 473.589.7

					төгрөгийн өртөгтэй барилгын өргөтгөл, засвар, Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны 400.900.0 төгрөгийн өртөгтэй засварын ажил тус тус дуусч ашиглалтад хүлээн авсан. Цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны засвар, зураг хийлгэх зардалд 1.0 тэрбум төгрөгийг Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсөвт тусган баталж, дэмжлэг үзүүлэх тухай 01/780 дугаар албан бичгийг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.
1.3.	Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулах, техникийн дэвшлийг нэвтрүүлэх	Онол, практикийн хурал, судалгаа, шинжилгээний ажил зохион байгуулсан эсэх	0	1	Улсын төсөв Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас зохион байгуулсан “Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар дундын хамтарсан багаас зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах үйлчилгээний үйл явцыг тодорхойлох нь” сэдэвт, Соёлын яам, Үндэсний номын сантай хамтран зохион байгуулсан “Гэрэлт хөшөө, хад чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт эрдэм шинжилгээ-онол практикийн 3 хуралд оролцсон. “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2023 онд, “Сонгуулийн үед хэв журам сахиулах цагдаагийн байгууллагын ажиллагаа, анхаарах зарим асуудал” эрдэм шинжилгээний бага хурлыг 2024

					онд тус тус зохион байгуулж, төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах хэлтэс, тасгуудаас нийт 46 илтгэл ирүүлснээс 8 илтгэлийг шалгаруулж, хэлэлцүүлсэн. Тэргүүлэх 4 чиглэлийг тодорхойлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 ном товхимол, гарын авлагыг хэвлэлтэд оруулахад бэлэн болгоод байна.
		Техник хэрэгслийг шинэчилж, шинэ технологийг нэвтрүүлсэн эсэх	0	1	Цагдаагийн байгууллагын өөрийн бие даасан шилэн кабелин дэд бүтцэд холбогдоогүй орон нутгийн 32, Улаанбаатар хотын 4 байгууллагын сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, тоон суваг түрээслэх үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, "Скайнетворкс" ХХК-тай 120 сая төгрөгийн гэрээ байгуулан холболт хийсэн. Ингэснээр Мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал, мэдээллийн систем, сүлжээний тасралтгүй хэвийн ажиллагааг хангасан. Зөрчлийн хэрэг бүртгэх албанд зөөврийн принтер 16 , Интерполын үндэсний төв товчоонд өндөр үзүүлэлт бүхий суурин компьютер 27, инчийн дэлгэц, хавтгай скайнер тус бүр 1 ширхэг, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст нэн хэрэгцээ, шаардлагатай байгаа "Samsung Galaxy A-24" гар утас, гар станцын батерей 42 , утасгүй чихэвч 20, Зөөврийн камерын системийн цахилгаан шийдэл, Нийслэлийн цагдаагийн удирдах газарт нэмэлтээр үүрэг гүйцэтгэх автомашинд 50 ширхэг GPS-ийг тус тус худалдан авч, хүлээлгэн өгсөн.

					Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад 4,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нэн шаардлагатай дэлгэц 30, I-7 зөөврийн компьютер 15, сүлжээний тоног төхөөрөмж 290, хамгаалалтын лиценз 2 ширхэгийг тус тус худалдан авч, харьяа 81 анги, байгууллагад тараан олгосон. Цагдаагийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, технологийн үйл ажиллагаанд ашиглагдах программ хангамж, лиценз, тоног төхөөрөмжүүдийг 2024 оны 05 дугаар сард хүлээн авч, холбогдох тохиргоо суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн. Synology - “Нөөцлөлт, хадгалалт /код 2/115/” “ВертексМон” ХХК-ний инженерүүдтэй хамтран Synology сторэйжийг суурилуулан тохируулж, туршилтыг гүйцэтгэж, “policecloud” системд цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнээс вебээр хандах боломжтой, хэрэгцээт мэдээллийг дотоод сүлжээнд хадгалах байдлаар тохируулсан. Сүлжээний хамгаалалт галт хана /код 2.106.4/: Checkpoint - “ВертексМон” ХХК-ний инженерүүдтэй хамтран дотоод болон гадаад сүлжээний хамгаалалт галт ханыг суурилуулах, шилжүүлэх түүний холбогдох тохиргоог хамтран гүйцэтгэв. Шинээр худалдан авсан тоног төхөөрөмжийг суурилуулах ажлын хүрээнд нэгдсэн сүлжээний гарц дээр галт ханын төхөөрөмж “Checkpoint 6200, Maestro”, нэгдсэн удирдлагын
--	--	--	--	--	---

					төхөөрөмжийг суурилуулах, төхөөрөмжүүдийн шинэчлэл, шаардлагатай тохиргоог 2024 оны 06 дугаар сард суурилуулсан. “K2 Nintex” системийг зохиомол /Виртуал/ сервер үүсгэж, “Ай Ти Зон” ХХК-наар “K2 Nintex” системийг туршилтын хугацаанд ашиглах байдлаар суулгуулан ашиглах боломжтой болгон, БХТ-ийн жолоодох эрх олгох үйл ажиллагаанд ашиглагддаг 3 программ хангамжийг шинэчлэх, хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусган хүлээлгэж өгсөн. Эрүүгийн цагдаагийн албаны кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт цахим орчинд тавигдах мэдээлэлд мониторинг хийх “Сүмбээ” программ, Зөрчлийн хэрэг бүртгэх албанд Сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан дуу хоолой таньж хөврүүлэх, түлхүүр үг ашиглан дүн шинжилгээ хийж харьяалал тогтоох “Чимэгэ системс”-ийн төсвийг шийдвэрлэн тус тус нэвтрүүлсэн. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид хөгжүүлэлт хийж, цагдаагийн байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай мэдээлэлтэй шууд танилцах боломжийг бүрдүүлэх чиглэлээр "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-нд 15 ангилал, 59 үзүүлэлт бүхий хэрэгцээ шаардлагын захиалгыг хүргүүлэн, цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг “Fiscus” онлайн программ хангамжид шилжүүлж байна.
		Улаанбаатар хотын камерын тоо	3311 3375	20032 13356	Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт 7432, Нийслэлд 4087, нийт 11.519 камер, иргэн, аж ахуйн нэгж,

					байгууллагын дэмжлэгтэйгээр орон нутагт 25693, нийслэлд 47221, нийт 72914 камер, бүгд 84.443 камер суурилуулсан байна.Тухайлбал, “Аюулгүй хот”-ыг бий болгох зорилтын хүрээнд 2022 онд “Ногоон бүс” төслийг хэсэгчлэн зохион байгуулах ажлыг эхлүүлж, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны 19.7 га газрын 61 цэгт Монгол Улсын теле хяналтын тоног төхөөрөмжийн (MNS6423:2019) стандартыг хангасан 4 мегапиксел бүхий үзүүлэлт бүхий 145 ширхэг камерыг суурилуулан теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбон 24 цагаар тасралтгүй хяналт тавьж эхэлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны А/66 дугаар захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрийн жагсаал, цуглаан зохион байгуулагдах эрсдэл бүхий 38 эмзэг цэг, нийтийн тээврийн 30 автобусны буудалд биометрик өгөгдөл таних (царай) ухаалаг программ хангамж “IREX” 50 ширхэг лицензийг 5 серверийн хамт, бичлэг хадгалах төхөөрөмж 1 ширхэг, хөргөлтийн төхөөрөмжийг суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн. “Теле камерын хяналтын нэгдсэн төв”-ийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд, "Теле камерын хяналтын дэд төв"-үүдийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд тус тус байгуулахаар шийдвэрлэж, нийслэлийн автозамын 176 уулзварыг бүрэн камержуулахад шаардагдах 80.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж, ажлын гүйцэтгэгчээр “Бодь-Электроникс” ХХК шалгарсан ба
--	--	--	--	--	---

						нийслэлийн 6 дүүрэгт дэд төвийг байгуулах ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Орон нутагт 16 аймаг, Нийслэлд 3 дүүрэг, нийт 19 камерын хяналтын төв хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Дархан, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Завхан аймгуудын тохижилт үйлчилгээний ажил хийгдэж байна. Улаанбаатар хотод Багануур, Багахангай, Баянгол, Баязүрх, Налайх, Сүхбаатар дүүргийн тохижилтын ажил хийгдэж байна. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулсан хяналтын камерыг бүртгэх зорилгоор Camera.police.gov программыг ашиглалтад оруулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1	Холбоо, техник хэрэгсэл, программын шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Мэргэжлийн албадад шаардлагатай технологийг нэвтрүүлэн нэгдсэн нөөц “Дата төв” байгуулсан эсэх	0	1	Улсын төсөв	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй 73 төрлийн программ хангамж, санд дотоод аудит хийж, 14 програм хангамж (ашиглалт хангалтгүй 4, шинээр программ хангамж нэвтрүүлсэн тул үйл ажиллагааг нь зогсоосон 6, шинээр хөгжүүлэх шаардлагатай 4)-ын үйл ажиллагааг нь зогсоож, захиалагч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шинээр 7 буюу Хүүхдийн нэгдсэн бүртгэлийн систем, Станцын бүртгэл систем, Жолоочийн мэдээллийн систем, Тусгай дуут дохионы зөвшөөрлийн мэдээллийн сан, Нэгдсэн хайлт, Шүүхийн шийдвэр, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны ажил дүгнэх программ хангамжид системийн шинжилгээ хийн боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

					Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 1 дүгээр давхарт байрлах серверийн өрөөнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд ашиглаж буй программ, сангийн мэдээлэл бүхий нийт физик 28 сервер дээр 68 виртуал сервер үүсгэн ашиглаж байна. Шинээр 9 буюу СОЦАС (Сонгуулийн цахим сан)", "Цэргийн тоо бүртгэлийн нэгдсэн сан", "Жагсаал цуглаан идэвхтэй зохион байгуулдаг иргэдийн бүртгэл", "Хүний нөөцийн бүртгэлийн систем (ШИНЭЧЛЭЛТ)", "Санхүүгийн тайлан мэдээ", "Санамж бичиг, гэрээний бүртгэлийн сан", "Захиргааны хяналтын бүртгэл", "Онц чухал объектын бүртгэлийн сан", "Теле хяналтын камерын бүртгэлийн сан" зэрэг програм хангамжийг шинээр боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлж, мөн 26 программ хангамжид 162 нэмэлт хөгжүүлэлт хийж, өнөөдрийн байдлаар 75 программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.
		Богино болон хэт богино долгионы радио системийг шинэчилсэн эсэх	0	1	Улсын төсөв Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудлаас Цагдаагийн хэлтсийн байрыг шилэн кабелиар холбож, гүйцэтгэхэд нийт 1,531,420 төгрөгийн үнэ бүхий техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг угсарч, суурилуулсан. Ингэснээр Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсээс бусад анги, байгууллагатай радио холбоо зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хэт богино долгионы радио станцуудыг шинэчлэх төслийг АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар "Моторола сольюшн" компанитай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөн 2022, 2023 онд нийт

					12.0 сая ам.долларын санхүүжилтийг шийдвэрлэсэн боловч хөрөнгө оруулалт хийгдээгүй. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд 4.1.2.11-д “Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа төрийн тусгай байгууллагуудын харилцаа, холбооны систем, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх”-ээр тусгасан.
		Хар тамхи, хүн хамгаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэх мэт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай техник технологийн шийдэл, тэргүүн туршлагыг нэвтрүүлсэн байх	0	1	Улсын төсөв Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн алба хаагчдыг чадавхжуулах хүрээнд 2022 онд “Азийн сан” олон улсын байгууллагын дэмжлэгээр 50.000.000 сая төгрөгийн өртөгтэй орчин үеийн техник, хэрэгслийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Цагдаагийн газар, Тэгү хотын Цагдаагийн газартай хамтран 2022-2027 онд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын цахим сүлжээг өргөтгөх, дижитал нотлох баримт шинжлэх тоног, төхөөрөмж, хэрэгсэл, лабораторийг шинэчлэх, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чадавхыг бэхжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлж байна. Алба хаагчдын галт зэвсгийн буудлагын дадлага, сургалтыг чанаржуулах, зөв дадал эзэмшүүлэх чиглэлээр сум дахин цэнэглэх техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, “Evolution ITL Comm” загварын сум дахин цэнэглэх автомат төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт суурилуулан үйл ажиллагаанд ашиглах бэлэн байдлыг хангасан.

						Гар утсанд нэвтрэлт хийх, устгасан зүйлийг сэргээх зориулалт бүхий Бүгд Найрамдах Чех Улсын Compelson компанийн “MOBILedit Forensic PRO” хувилбарыг туршилтаар ашиглах нэвтрэх эрхийн нууц кодыг авч, 2023 оны I улиралд үйл ажиллагаандаа туршилтаар хэрэгжүүлж, цаашид ашиглах хэрэгцээ, шаардлага бий эсэх талаар танилцуулга, саналаа холбогдох нэгжид хүргүүлсэн. Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)-ын тархцад хяналт тавих, шинээр тархцын цэгийг олж тогтоох ажилд зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлэх зорилгоор НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хэрэгжүүлдэг “Хууль бус талбайн хяналтын хөтөлбөр” (Illicit crop monitoring programme)-ийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр төвлөсөн. Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагаанд шаардлагатай 13 нэр төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа, танилцуулгыг бэлтгэж 30 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг 2024 оны 19/617 дугаартай албан бичгийг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлээд байна.
3.1.	Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай ажиллах	Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай харилцах, хамтран	2	6	Улсын төсөв	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газар, Тэгү хотын цагдаагийн газартай хамтран 2022-2027 онд хэрэгжүүлэх төсөл, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-аас Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамтай

		ажиллах гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, төслийн тоо				хамтран 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж буй Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчдыг чадавхжуулах төсөл, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яам хоорондын 2022-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүгийн цагдаагийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын Өөртөө Засах орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”, Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэгү хотын цагдаагийн газар хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”, Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага болон Оросын Холбооны Улсын Үндэсний гвард, Бүгд Найрамдах Турк Улсын Жандармерийн ерөнхий командлал хоорондын харилцан ойлголцлын “Санамж бичиг”, Дотоодын цэргийн байгууллага болон Оросын Холбооны Улсын Үндэсний гвард хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”, мөн Бүгд Найрамдах Турк Улсын Жандармерийн ерөнхий командлал хоорондын “Хамтын ажиллагааны протокол”, Цагдаагийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Эль эмнэлэг хоорондын “Хамтран ажиллах гэрээ”, “Korean air” ХХК-тай “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус байгуулан хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Хууль зүй дотоод хэргийн яамны оролцоотой зохион байгуулж байгаа “Монгол Улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөл”-
--	--	--	--	--	--	--

					ийг Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран хэрэгжүүлж байна.
					Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлж, сургалтад хамруулах зорилгоор Бүгд Найрамдах Филиппин Улс, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран ажиллаж байна.
					Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотын Дотоод хэргийн удирдах газар, Цагдаагийн ерөнхий газар, Сингапур Улсын “ST Engineering” компанитай хамтран ажиллах санамж бичгийн төсөл зэргийг боловсруулж, бэлтгэл ажлыг хангаж байна.
		Гадаадын улс орон, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан албаны сургалтын тоо	3	9	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020-2024 онд гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллагуудтай хамтран 58 удаагийн сургалтад нийт 894 алба хаагчийг хамруулсан.
		Гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлал,	3	9	Гадаад улсад буюу АНУ-12, Филиппин-9, Турк-15, Швейцар-1, Англи-5, Узбекистан-1, Словени-2, Франц-1, Вьетнам-2, БНСУ-46, ОХУ-46, БНХАУ-26, Египет-2, Нидерланд-2, Тайланд-6, Канад-6, Сингапур-2, Австри-2, Литва-2, Герман-1, Япон-1, Индонез-3 нийт 193 алба хаагчийг тус тус холбогдох сургалтуудад хамруулж, гадаад улсын ололт амжилт, сайн туршлагыг харилцан солилцох ажлыг зохион байгуулж ажиллалаа.
					Цагдаагийн ерөнхий газрын удирдлагууд Сингапур, БНТУ, АНУ, Япон, ОХУ, БНХАУ, Узбекистан, БНСУ, Канад, БНХАУ, НҮБ,

		уулзалт, алба хаагчдын гадаад улсад хийх албан томилолтын тоо				Австрали зэрэг нийт 15 орны хууль сахиулах байгууллагын төлөөлөгч нарыг хүлээн авч уулзан, 17 албан айлчлалыг зохион байгуулж ажилласан. Уулзалтаар хоёр улсын Цагдаагийн байгууллагын нөхөрсөг хамтын ажиллагаа, хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар ярилцаж, цаашид хамтын ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, туршлага солилцох талаар санал солилцсон.
Зорилт 4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.						
4.1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх	Нийт гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	51.9	60	Улсын төсөв	Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг өргөтгөн зохион байгуулах, гүйцэтгэж буй чиг үүргийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд Урьдчилан сэргийлэх хэлтсийг газар болгон өргөжүүлж, Засгийн газрын 2024 оны 177 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, Урьдчилан сэргийлэх газрыг алба болгон өргөжүүлсэн. Алба болгон өргөжснөөр урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг, үүргийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, бие даасан үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлсэн. Гэмт хэргийн илрүүлэлтийг зорилтот түвшинд хүргэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2024.07.09-ний өдөр тус албаны даргын А/53 дугаартай тушаалаар байгуулагдаж, нэгдсэн төлөвлөгөө, удирдамж гарган алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлж, тэдгээртэй цахимаар 4 удаа хуралдан, 4 удаагийн үүрэг, ажлын чиглэлийг албан бичгээр хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

					Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1, 9.1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэн, нэгдсэн төлөвлөлтийг мөрдөж, илрүүлэлт шийдвэрлэлтийг ахиулахын зэрэгцээ гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн ажил, арга хэмжээний саналыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс авч нэгтгэн Цагдаагийн байгууллагаас 2024 онд зохион байгуулж хэрэгжүүлэх тусгай-15, хэсэгчилсэн-441 ажил, арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө, хуваарь, “Мэдээлэл, ажлын чиглэл”-ийг боловсруулж энэ оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 18/244 дугаар албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудад хүргүүлж, улсын хэмжээнд 4 аян, нэгдсэн 11, хэсэгчилсэн 921 нийт 936 арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан. Улсын хэмжээнд 38.3 хувь, нийслэлд 33.5 хувь, орон нутагт 52.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 9.3 нэгжээр, нийслэлд 13.2 нэгжээр тус тус буурч, орон нутагт 1.9 нэгжээр өссөн. Хэргийн илрүүлэлт буурахад дараах хэд хэдэн шалтгаан нөлөөлсөн. Үүнд: Хэрэг бүртгэлтийн 25273 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2740 хэрэг буюу 12.2 хувиар өсч, үүнээс 9689 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 1046 буюу 9.7 хувиар буурсан. Хүний амьд явахын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт 4.9, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг хэргийн илрүүлэлт 2,7, өмчлөх эрхийн эсрэг
--	--	--	--	--	---

					хэргийн илрүүлэлт 7.2, эдийн засгийн гэмт хэргийн илрүүлэлт 2.1 хувиар тус тус буурч улсын хэмжээнд илрүүлэлт буурсан үзүүлэлттэй байна. Цагдаагийн байгууллагын албан ёсны “Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв” гэх нэршил бүхий фэйсбүүк хуудаст цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах, мэдээ-307, видео мэдээ-499 /рийл 273/, зурагт хуудас-340, 7 шууд дамжуулалт зэрэг нийт 1,229 мэдээлэл бэлтгэн цахим хуудаст байршуулсан нь 1,288,395 хэрэглэгч таалагдсан, 880,142 хэрэглэгч бусадтай хуваалцсан, 140,370 иргэн сэтгэгдэл илэрхийлж давхардсан тоогоор 135,859,313 хэрэглэгчийн хандалт авсан байна.
		Мал хулгайлах гэмт хэргийн бууралтын тоо	1041	900	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран ажиллах 01/23 дугаартай санамж бичгийг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулж Мал эмнэлгийн цахим гэрчилгээний шинэчилсэн хувилбар болох “МЭНС-II”-ийн ашиглалтад оруулсан. Мах боловсруулах үйлдвэр, мал нядалгааны газрууд, мах, түүхий эд худалдан авдаг цэг, хүнсний дэлгүүр бүхий 28 аж ахуйн нэгж, байгууллагын гадна талын шилэн кабелийн дэд бүтцэд түшиглэн 3,4 км шилэн кабел татаж нийт хяналтын 23 цэгт 60.100.000 төгрөгийн үнэ бүхий 41 ширхэг камерыг суурилуулж, Налайх дүүргийн Шуурхай удирдлага хяналт, мэдээллийн төвтэй шилэн кабелиар холбож, 64 сувгийн 80 терабайт

					багтаамжтай, 60 хоног хадгалах бичлэгийн төхөөрөмжийг суурилуулан, 24 цагийн байнгын хяналт тавин ажиллаж байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэр “Эмээлт”-д үйл ажиллагаа явуулж байгаа мах боловсруулах үйлдвэр, мал нядалгааны 55 аж ахуй нэгжид 115 ширхэг стандартын шаардлага хангасан теле-хяналтын камерыг Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулж, 9 нэр төрлийн 26 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авч, сүлжээний бааз станцыг шинээр байгуулахад шаардагдах 19.568.000 шийдвэрлүүлж утасгүй сүлжээний 4 бааз станцыг байгуулсан. “Малчин лавлах-109” төвтэй хамтран ажиллаж тус төвийн 109 тусгай дугаарын утсанд 2024 онд алдсан, олдсон малын нийт 32 дуудлага ирснээс 21 дуудлага нь алдсан малын, 11 дуудлага нь олдсон малын тухай дуудлага мэдээллийг нутаг дэвсгэрт хариуцсан цагдаагийн байгууллагын газар, хэлтсүүдэд хүргүүлсэн. 2024 онд Улсын хэмжээнд яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хулгайлах төрлийн 3915 хэрэг бүртгэлтийн хэргээс шийдвэрлэх боломжтой хулгайлах төрлийн хэргийг богино хугацаанд шийдвэрлэж гэмт хэргийн илрүүлэлтийг 40% хувьд хүргэх зорилгоор зохион явуулж буй “Хянамгай байя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулж буй “Тор” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр тус тасгаас алба хаагчдаас давхацсан тоогоор 5
--	--	--	--	--	--

					алба хаагч Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Булган, Завхан, Говьсүмбэр аймгуудад 5 удаагийн албан томилолтоор ажиллаж 7 бүлгийн 28 этгээдийг дайчлан баривчилж 77 хэргийг илрүүлж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад шилжүүлэн ажилласан. Мал хулгайлах гэмт хэргийн гаралт 2021 онд 743 бүртгэгдсэн бол 2022 онд 35 нэгжээр буюу 4.5 хувиар өссөн, 2023 онд 643 буюу 135 нэгжээр буюу 17.4 хувиар буурсан, 2024 онд 508 буюу 135 нэгжээр буюу 21.0 хувиар буурсан.
		Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо	1138	1251	2024 оны байдлаар цагдаагийн байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 1 аян, 3 нэгдсэн арга хэмжээ, Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн өдөрлөг”, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхэд таныг хамгаалъя” өдөрлөг 2, “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эрэгтэйчүүдийн оролцоо”, “Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн зохицуулалт” зэрэг 2 хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулан ажилласан. Тухайлбал: Олон улсын эмэгтэйчүүдийн баяр, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан “Харилцан хүндэтгэе” мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг 2024 оны 03 дугаар сард 20 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2 контент, 4 постер, 15 төрлийн зурагт хуудсыг бэлтгэн тарааж, мэдээллийг 19 телевиз, 40 сайтад байршуулж,

					2100 цахим группт түгээсэн нь 1.200.000 хүнд хүрч, 750,000 хүнд таалагдсан байна. Энэ хугацаанд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 73 мэдээлэл хоногийн мэдээнд бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 37.8, өмнөх сараас 8.4 хувь тус тус буурсан. Хүүхдийг үе тэнгийн дээрэлхэл, дарамт, гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” мэдээлэл сурталчилгааны аяныг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулсан. Ухуулга нөлөөллийн 50.000 ширхэг зурагт хуудсыг хэвлүүлж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлэн, сургуулийн орчин, гудамж талбай олон нийтийн газар, аж ахуй нэгж байгууллагад байрлуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг төрийн өмчийн 2, хувийн хэвшлийн 19 автобус компанитай хамтран нөлөөллийн зурагт хуудас, шторкийг автобус болон цахилгаан шатны 1118 дэлгэцэд байршуулсан. “Та намайг мэднэ ээжээ” дууг “Grow” студи, дуучин Thunder буюу Г.Өлзий-Учралтай хамтран зохион бүтээж, клипжүүлэн нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 23 богино долгионы радио, 15 телевизээр нэвтрүүлж байна. Ухуулга нөлөөллийн 4, сэрэмжлүүлэх видео контент 4, аяны нөлөөллийн дуу клип 1, мэдээлэл өгөх зурган постер 30, мэдээлэл 25, мэдээ 16 зэрэг нийт 171 мэдээ, мэдээлэл, контентыг инстаграм, твиттер, фэйсбүүк платформд байршуулан сурталчилснаар 16.788.824 цахим хэрэглэгчдэд хүрч, 159.209 хүн бусадтай хуваалцаж, 295.757
--	--	--	--	--	--

						хүнд таалагдсан байна. Аяны үр дүнд насанд хүрээгүй хүн холбогдсон 19, хохирсон 51 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9,5 хувь буурсан эерэг үзүүлэлттэй байна. 2024 онд 36906 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5648 хэргээр буюу 18.1 хувиар өсч, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 897 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 103 хэргээр буюу 10.3 хувиар буурч, Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн 2413 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 629 хэргээр буюу 35.3 хувь өсжээ.
4.2.	Иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюулгүй техник, тусгай хэрэгслийг ашиглах	Аминд үл хүрэх тусгай хэрэгслийн хангалт, ашиглалтын төрөл	6	10	Улсын төсөв Улсын төсөв	2022 онд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад сургалтын зориулалтаар аминд үл хүрэх “9x19 мм-ийн лугер”, “9x18 мм-ийн ПМ”, “7,62x39 мм-ийн ПС” загварын резинэн хошуутай сумыг тус бүр 2000 ширхэгийг олгосон. 2024 онд Цагдаагийн байгууллагын Тусгай бүлгийн алба хаагчдад олон улсын жишигт нийцсэн чанар, өнгө үзэмж бүхий тусгай зориулалтын хамгаалах хувцас, хэрэглэлээр хангах зорилгоор бэлтгэн нийлүүлэгч байгууллагыг нээлттэй сонгон шалгаруулж, “Алтан долгио” ХХК, “Бродер мерчинс” ХХК, “Дельта партнерс” ХХК-иудаас “Uf-Pro”, “Lowa”, “5.11”, “Helikon tex” брэндийн 36 нэр, төрлийн хувцас хэрэглэлийг худалдан авч, хангалтаар олгоод байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Дотоодын цэргийн 809 дүгээр ангийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай 900,0 сая төгрөгийн үнэ бүхий 12 нэр, төрлийн дуулга, бамбай, хантааз, ялтас, нүдний шил, бүс, бээлий, бууны гэр, үүргэвч зэрэг

						тусгай зориулалтын хамгаалах хэрэглэлийг олгож шийдвэрлэсэн. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад 8 нэр, төрлийн нийт 103 ширхэг галт зэвсэг, дагалдах хэрэглэлийг 1,3 тэрбум төгрөгөөр худалдан авч, анги, байгууллагад хуваарилсан.
		Стандартын шаардлага хангасан тусгай хэрэгслийг ашигласан эсэх	0	1		2022 онд олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик-арга зүйг сайжруулахад цагдаа, дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнд шаардлагатай 21 төрлийн 249.018 нэгж нэг бүрийн тусгай болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг 38.829,5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. 2024 онд БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Нийгмийг аюулаас хамгаалах яамны буцалтгүй тусламжаар олгосон 9 нэр төрлийн 450 ширхэг 218 сая төгрөгийн үнэ бүхий тусгай хэрэгслийг орлогод авч Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хүлээлгэн өгч, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг чиглэлээр үйл ажиллагаанд ашиглаж байна.
4.3.	Яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах тусгай зориулалтын дуудлага холболтын станц /IP-PBX/-ыг шинэчлэх	Дуудлага, мэдээлэл хүлээн авах тоног төхөөрөмжийн тоо	0	1	Улсын төсөв	Яаралтай тусламжийн E1N системийн дуудлага, холболтын IP-PBX серверүүдийн нөхцөл байдал, шинэчлэхэд шаардлагатай зардлын тооцоог хийж, 2021 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулснаар Хууль зүй, дотоод хэргийн яам, сайд, мөн Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргад 03 дугаар сарын 24-ны өдөр албан бичгийг хүргүүлснээр дуудлага, мэдээлэл хүлээн авах тусгай зориулалтын дуудлага холболтын станцыг шинэчлэх 720 сая

					төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хамгийн сүүлийн үеийн техник, технологиор яаралтай тусламжийн дуудлагыг хүлээн авч эхэлсэн. Яаралтай тусламжийн дуудлага холболтын системийн тоног төхөөрөмжийг шинэчилснээр дуудлага хүлээн авах шугамуудыг оновчтой зохион байгуулах, дуудлага хуваарилах, алба хаагчийн ачааллыг тэнцвэржүүлэх, дахин холбогдсон хүнийг өмнөх оператортай холбох, интернэт сүлжээ ашиглан дурын байршлаас дуудлага хүлээн авах, төрөл бүрийн судалгаа, шинжилгээ, статистикийг нарийвчлан гаргах, олон улсын жишиг (112, 911 г.м) нэгдсэн дугаарлалтад шилжих суурь нөхцлийг бүрдүүлсэн. 102 тусгай дугаарт гадаад хэлээр ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар дуудлага, мэдээллийг “Ярих-орчуулах” хэлбэрээр орчуулах орчуулгын төхөөрөмжийг ашиглаж, Иргэний гар утсанд дүрст дуудлага хийх холбоосыг мессежээр илгээн дүрст дуудлага хийж буй байршлын мэдээллийг “Google map” системээр дамжуулан авах боломжтой болсон. Мөн Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэл өгөхдөө хаяг, байршил, байгаа газраа мэдэхгүй тохиолдолд “E-Mongolia” аппликейшны нэмэлт цэсээр нэвтэрч “3 үгт хаяг” /what3words/ дарснаар байршлаа хялбархан тогтоох боломжтой болсон. Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа дуудлага, гомдол, мэдээлэл, эрүүгийн болон
--	--	--	--	--	---

						зөрчлийн хэргийн шалгаж, шийдвэрлэгдэж байгаа хугацааны мэдээлэл, иргэний өөрт хамаарах мэдээлэл, эрэн сурвалжилж байгаа хүний мэдээлэл, шуурхай зарлан мэдээлэл зэргийг багтаасан “102 police” аппликейшнийг ашиглалтанд оруулсан.
4.4.	Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй, дулааны цахилгаан станц, зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршилт ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэр, стратегийн орд газрыг хамгаалалтад авах	Хамгаалалтад авсан онц чухал объектын тоо	5	21	Улсын төсөв	“Тайширын усан цахилгаан станц”-ыг хамгаалалтад авахад шаардагдах орон тоо, зардал нь 2021 оны улсын төсөвт тусгагдаагүй тул орон нутгийн төсвөөс, эсвэл тогтоолд өөрчлөлт оруулан хамгаалуулагч байгууллагаас шийдвэрлүүлэх боломжтой эсэх талаар санал авах хүсэлтийг Говь-Алтай аймгийн засаг даргын Тамгын газар, “Ундрага-Алтай” ААТҮГ, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-нд хүргүүлэхэд Говь-Алтай аймгийн засаг даргаас “Тайширын усан цахилгаан станцыг хамгаалах дотоодын цэргийн тусгай салбар”-ыг эхний ээлжид 25 орон тоотойгоор байгуулж, шаардагдах 483.3 сая төгрөгийн төсөв зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэх саналын дагуу Дотоодын цэргийн командлагчийн 2021 оны мн/ дугаар тушаалаар “Дотоодын цэргийн тусгай салбар”-ыг байгуулан, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг баталж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс зарласан төрийн албаны сонгон шалгаруулалтад тэнцсэн 19 иргэнийг дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжил олгох сургалтад хамруулж, тус усан цахилгаан станцыг Дотоодын цэргийн тусгай салбарын хамгаалалтад 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хүлээн авч, харуул, хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулснаар Засгийн газрын тогтоолын хэрэгжилт хангагдсан.
		Хамгаалалтад авсан стратегийн орд газрын тоо	1	2	Улсын төсөв	

					Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Сайншанд, Мөрөн хотуудын хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, "Дарханы дулааны цахилгаан станц", "Дорнод бүсийн эрчим хүчний систем", "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" зэрэг 8 барилга, байгууламжийн хамгаалалтыг дотоодын цэргийн хамгаалалтад авах Засгийн газрын 2024 оны 35 дугаар тогтоолыг гаргуулсан. Тогтоол гарсантай холбогдуулж, Дотоодын цэргийн командлагчийн энэ оны мн-1а/11 дүгээр тушаалаар Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь, Хөвсгөл аймгуудад дотоодын цэргийн тусгай салбарыг байгуулж, Цэцэрлэг, Арвайхээр, Баянхонгор, Мөрөн хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, Дархан, Эрдэнэт, Дорнод аймгийн дулааны цахилгаан станцыг дотоодын цэргийн хамгаалалтад бүрэн авсан. Мөн Налайх дүүргийн 5,6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дээд эх үүсвэрийн гүний худаг, усан сан, Налайхын усан сангийн барилга байгууламжийн хамгаалалтыг 04 дүгээр сарын 10-ны өдрөөс Дотоодын цэргийн 836 дугаар салбарын хамгаалалтад шилжүүлсэн. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, дулааны станцыг дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад авах, “Цагааннуур” чөлөөт бүсийн дотоодын цэргийн гэрээт хамгаалалтыг төсөвт хамгаалалтад, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт байрлах Монголын газрын тосны үйлдвэр, Бор хөөврийн говийн ус хангамжийн эх үүсвэрийн
--	--	--	--	--	--

						объектуудыг хамгаалалтад авах холбогдох санал, танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.
4.5.	Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийг дагаж гарах журам, дүрэм боловсруулах, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцсон эсэх	0	1	Улсын төсөв	“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулж, 2022 оны 2/413 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, 2/49 дугаартай албан бичгээр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тус тус хүргүүлсэн. Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хувийн хамгаалалтын тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Амьтны тухай хууль тогтоомжийг дагаж гарах 8 журмын төсөл боловсруулж, 25 журам, дүрмийн төсөлд холбогдох саналыг тусган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэх цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хийгдсэн бүтцийн өөрчлөлттэй уялдуулах, хэм хэмжээний актуудын хийдэл, давхардал, зөрчлийг арилган Цагдаагийн

						байгууллагын үйл ажиллагааны 9 бүлэг 267 журмыг нэгтгэн 9 бүлэг 182 журам болгон шинэчлэн баталж, нийт алба хаагчдадаа танилцуулан, сургалт зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар мэдээлэл, зөвлөмжийг 2024 оны 5г/7580 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн.
4.6.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/250 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг”-ийг баталсан. Бодлогын баримт бичгийг үндэслэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, төрөл мэргэжлийн албадын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар байгуулан Тэргүүн дэд даргаар ахалсан ажлын хэсэг ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв”-ийг байгуулсан. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төвийг байгуулснаар цагдаагийн байгууллага 300-400 хохирогчтой болсны дараа илрүүлдэг байсан асуудлыг байхгүй болгож, иргэдийг цахим гэмт хэргийн хохирогч болохоос өмнө, гэмт этгээдэд мөнгө, эд хөрөнгөө залилуулахаас өмнө илрүүлэх боломжтой болсны үр дүнд 2024 онд 1,628 дуудлага мэдээлэл хүлээн авч 5.7 тэрбум төгрөгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлан,

						115 иргэнд 1.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. 2024 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр 12 бүлгийн 105 тусгайлсан ажил, арга хэмжээг төлөвлөн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн бөгөөд биелэлт, үр дүнг сар бүр тооцож, энэ оны эхний 11 сард “Бодлогын зөвлөл” нийт 5 удаа хуралдаж тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэлэлцсэн. Мөн 2025-2028 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний стратеги төлөвлөгөөний төсөл, 2025 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлыг 34 заалттай ажлын санал, төсвийн судалгааны хамт боловсруулж, цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн даргат танилцуулан 2/373 дугаартай албан бичгээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.
4.7.	Согтуурах, мансуурах донтой хүний албадан болон сайн дурын эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, нийгэмшүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Улсын хэмжээнд хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэн иргэдэд архи согтууруулах ундаанаас татгалзах нөлөө үзүүлэх, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөвийг зөвлөө”, “Архины хэрэглээ ба түүний хор нөлөө”, “Архины хор хөнөөл”, “Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг”, “Үлгүй-Үйлдэл”, “Ахуйн хүрээний архидалт”, “Архигүй сүмбэр”, “Архигүй Монгол айл”, “Архидалтгүй ирээдүй төлөө”, “Согтуу”, “Архигүй орчин, айдасгүй гэр бүл”, “Эргүүл 1,2,” “Намайг алгас” зэрэг ерөнхий арга хэмжээ 11, тусгай арга хэмжээ 445, соён

					гэгээрүүлэх 15, нийт 610 ажил, арга хэмжээ зохион байгуулсан. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан 20 цагдаагийн байгууллага /Нийслэлийн 4 дүүрэг, 16 аймаг/-аас хөтөлбөр, төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэхтэй холбоотой 2.3 тэр бум төгрөг шийдвэрлүүлж, тайлант хугацаанд 62 төрийн болон төрийн бус байгууллага, АА нийгэмлэг, бүсийн оношилгооны төв, сэтгэц наркологийн тасагтай хамтран ажиллаж, сайн дурын эмчилгээнд 497, албадан эмчилгээнд 286 иргэнийг хамруулж, 356 удаа сургалт, зөвлөгөөнд 18640 иргэнийг хамруулж, архины хамгаалалттай иргэдэд чиглэсэн 5 өрөө, кабинетыг тохижуулсан. МУ-д Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл бусад төрийн дээд шатны байгууллагад нийт 69 санал бүхий 55 танилцуулгыг хүргүүлж 44 санал буюу 63.8 хувийг нь шийдвэрлүүлсэн байна. Үүнээс тогтоол 6, захирамж 15, хөтөлбөр 2, бусад төрлийн 21 шийдвэр гарч, 158.201.000 төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар иргэн, аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл 742, шаардлага 566 хүргүүлснээс 905 хариуг авч, тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй, хариу ирүүлээгүй 121 аж ахуй нэгж, 57 иргэнийг нийт 232.950.000 төгрөгөөр торгох арга хэмжээг авсан. Цагдаагийн байгууллагаас энэ оны эхний 11 сарын байдлаар иргэдийн аюулгүй амар тайван
--	--	--	--	--	--

					амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гудамж талбайд удаа дараалан архидан согтуурч бусдын амгалан тайван байдал алдагдуулдаг тэнэмэл байдлаар амьдардаг давхардсан тоогоор нийт 956 хүнийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулж, 615 хүнийг төрийн болон төрийн бус байгууллага, ар гэрийнхэнд хүлээлгэн өгсөн бол 341 хүнийг Иргэний хэргийн анхан шатны шүүхээр оруулж, архины албадан эмчилгээнд хамруулсан. Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдол хүлээлгэх хариуцлагын талаар телевизэд 28 удаа, сайтад 42 удаа, радиод 35 удаа, сонинд 3 удаа тус тус мэдээлэл, ярилцлага өгч, 2232 жолооч, ажилтан нарт сургалт зохион байгуулж, 981 ширхэг сурталчилгааны материалыг тарааж, нийслэлийн хэмжээнд 9 байршилд лед дэлгэцээр бэлтгэсэн видео контентуудыг байршуулж, байгууллагын цахим хуудсанд 9 видео шторк, 11 зурагт хуудас, 5 видео контент, 3 рийл нийт 47 мэдээлэл байршуулсныг нь 8.791 хүн дэмжиж, 22.266 удаа бусадтай хуваалцаж, 12.783 хүнд таалагдаж, 1.049.250 хүнд хүрсэн байна. Арга хэмжээний хүрээний үр дүнд согтуугаар үйлдэгдсэн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 18 нэгжээр буюу 13.7, хөлдөж, осгож амь нас хохирсон хүний тоо 4 нэгж буюу 25 хувиар тус тус буурч, эргүүл хяналт шалгалтын ажил эрчимжсэнээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг, зөрчил 110 нэгж буюу 3.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
--	--	--	--	--	--

4.8.	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах цогц арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн хор уршиг, иргэдийн мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх, бүртгэгдсэн хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 75 цагийн танхимын болон цахим сургалт хийж, 764 цагдаагийн алба хаагчийг хамруулсан. Тухайлбал: “Хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага, мэдээлэл хүлээн авахад анхаарах асуудал”, “Дуудлага мэдээллийн ECS программ хангамжийн хөгжүүлэлт давтамжтай дуудлага мэдээлэл бүртгэх”, “Аюулын зэргийн үнэлгээ хийх, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн дуудлага мэдээлэл шийдвэрлэх аргачлал”, “Гэр бүлийн хүчирхийллийг таньж илрүүлэх нь”, “Алба хаагчид хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцахад анхаарах асуудал”, “НҮБ-ын Хүн амын сантай хамтран холбогдох талуудад нотолгоонд суурилсан бодлогын арга хэмжээ авахад туслах GBV цахим сангийн мэдээлэлд хагас жил тутам бодитой дүн шинжилгээ хийх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургагч багш бэлтгэх сургалт”, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газартай хамтран Фронзик ярилцлага хийх сургагч багш бэлтгэх сургалтад Нийслэл төвийн 6 дүүргийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд болон гэр бүлийн хамгааллын ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийг хамруулсан.
Хоёр. Улсын хил хамгаалал						
Зорилт 1.Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.						
1.1.	Хил хамгаалах байгууллагын бодлогын	Шинэчлэн боловсруулсан бодлогын	0	1	Улсын төсөв	Ажлын хэсэг төслийг боловсруулж, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэх үндэслэл, саналыг Хууль

	баримт бичиг, дүрэм, хөтөлбөрийг шинэчлэх	баримт бичгийн тоо	0	1		зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч яамнаас “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан түр хугацаанд хойшлуулах чиглэл өгсөн.
		Улсны Их хуралд өргөн мэдүүлсэн эсэх				Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 3 зорилт тусган батлуулснаар Хил хамгаалах байгууллагыг хөгжүүлэх, хил хамгаалалтыг шинэ шатанд гаргах нөхцөл бүрдсэн.
	Шинэчлэн боловсруулсан дүрмийн тоо		0	1	Улсын төсөв	“Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийг өөрчлөх хэрэгцээ, шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ажлын хэсэг байгуулан, Хил хамгаалалтын I, II ангийн дүрмийн төслийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 01 дүгээр зарлигаар “Улсын хил хамгаалалтын дүрэм”-ийг батлуулсан. Үүнд:
	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн эсэх		0	1		Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 2023 оны мн/228 “Хилийн цэргийн анги, тусгай салбарын байршил тогтоох тухай”, мн/229 “Хилийн цэргийн анги, тусгай салбарын зэрэглэл тогтоох тухай”, мн/464 “Алслагдсанд тооцох хилийн цэргийн анги, салбарын жагсаалт батлах тухай”, 2024 оны 141 дүгээр зарлигаар “Цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол, ялгах, тэмдгийн загвар” тус тус батлагдсан.
	Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийн тоо		0	3		Засгийн газрын 2023 оны 464 дүгээр тогтоолоор “Алслагдсанд тооцох хилийн цэргийн анги, салбарын жагсаалт”, 2024 оны 61 дүгээр тогтоолоор “Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагчид
			0	1	Улсын төсөв	

						албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам” батлагдсан. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж импортлох, бүртгэх, хилийн хэсэгт нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглах харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулах талаар Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд санал хүргүүлсэн.
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
2.1.	Олон улс ба орон нутгийн нисэх буудал, авто замын болон төмөр замын шалган нэвтрүүлэх салбарыг шинээр байгуулах, нүүлгэн шилжүүлэх	Шинээр байгуулах шалган нэвтрүүлэх тоо Нүүлгэн шилжүүлэх салбарын тоо	0 0	8 1	Улсын төсөв	“Боршоо” боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажил дуусч, 2023 оны 12 дугаар сараас бүрэн ашиглалтад оруулсан. “Цагаандэл-Уул” боомтын бүтээн байгуулалтын ажил эхлээд явагдаж байна. Агаарын замын “Даланзадгад”, “Мөрөн” нисэх буудалд шаардлагатай шалгалт хамгаалалтын тоног төхөөрөмжийг бэлтгэсэн. Увс, Хөвсгөл, Өмнөговь аймгуудад Олон Улсын нисэх буудалд шалган нэвтрүүлэх салбарыг шинээр байгуулах, бүтэц, орон тооны санал, Олон Улсын нисэх буудалд шалган нэвтрүүлэх салбарыг шинээр байгуулах бүтэц, орон тооны саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргэсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.
2.2.	Сансрын холбоогоор холбогддог хилийн боомтуудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбох	Шилэн кабелийн сүлжээнд шинээр холбогдсон боомтын тоо	0	9	Улсын төсөв	Хил хамгаалах байгууллагын шилэн кабелийн дэд бүтцийг байгуулах, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Мэдээлэл холбооны сүлжээ”, “Юнител”, “Мобиком” ХХК-уудтай хамтран 42 цэгийн холболтыг шилжүүлэн, шинээр хилийн цэргийн 2 анги (0306, 0198), авто замын 3 боомт (Бургастай, Ханги, Хавирга)-ыг шилэн кабельд холбосон.

						Байнгын ажиллагаатай хилийн 24 боомтоос 18 боомт шилэн кабель, 6 боомт Всат системийн сүлжээнд тус тус холбогдсон. Хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангийн хариуцсан хэсэгт 72,5 километр газар мэдрэгчтэй шилэн кабелийн дохиоллын системээр төхөөрөмжилсөн.
2.3.	Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг шинэчлэх	Шинэчлэн байгуулах торон саадны урт	0	828.8 км	Улсын төсөв	Хилийн цэргийн 6 анги (0101, 0130, 0132, 0214, 0275, 0285)-ийн хариуцсан хэсэгт нийт 40.0 км өргөст торон саад байгуулсан. Хилийн цэргийн 0306 дугаар ангийн хариуцсан хэсэгт 25.3 км өргөст торон саад, 0245, 0275 дугаар ангиудын хариуцсан хэсэгт 60 км спираль торон саад тус тус шинээр байгуулж, улсын хил хамгаалалтад шилжүүлсэн. Хилийн цэргийн 4 анги (0146, 0184, 0198, 0275)-ийн хариуцсан хэсэгт 112.1 км торон саадын шон суулгаж, бусад материалыг татан авсан. Хилийн цэргийн 0132, 0146, 0168, 0184, 0198, 0275, 0306 дугаар ангиудын хариуцсан хэсэгт нийт 431.7 км хилийн торон саад байгуулсан. Хилийн цэргийн 14 ангийн хариуцсан хэсэгт 753.8 км торон саад нэмэлтээр хийж гүйцэтгэсэн.
		Шинээр байгуулах хянах цамхагийн тоо	0	35		Хилийн цэргийн 3 анги (0132, 0184, 0275)-ийн хариуцсан хэсэгт 5 хянах цамхаг, хилийн цэргийн 0129 дүгээр ангийн хариуцсан хэсэгт 1 хянах цамхаг шинээр байгуулж, 2 анги (0198, 0275)-ийн хариуцсан хэсэгт 2 хянах цамхаг засварласан. Увс аймгийн Баруунтуруун сум дахь хилийн цэргийн 0311 дүгээр ангийн “Цагаан гатлага”

					хилийн харуулд 1 ширхэг хянах цамхаг, 0277 дугаар ангийн “Арцсуурь” боомтын хэсэгт 1 ширхэг камерын цамхаг тус тус шинээр байгуулж, ашиглалтад оруулсан. Хилийн цэргийн 0146, 0198 дугаар ангийн хариуцсан хэсэгт 2 хянах цамхагийг шилжүүлэн байрлуулж, засварласан.
	Шинээр байгуулах төмөр саадын байгууламжийн урт	0	16 км		Хэнтий аймаг дахь хилийн цэргийн 0287 дугаар ангийн хариуцсан хэсэгт 16 км, 2023 онд Баян-Өлгий, Увс аймаг дахь 0285, 0245 дугаар ангиудын хариуцсан хэсэгт 32.1 км, нийт 48.1 км төмөр саадын байгууламж шинээр байгуулснаар төлөвлөснөөс 3 дахин давуулан хэрэгжүүлсэн.
	Шинээр байгуулах нүхэн саадны урт	0	59 км		Хилийн цэргийн ангиудын хариуцсан хэсэгт 39.2 км нүхэн саад шинээр байгуулсан.
	Шинээр байгуулах хамгаалалтын хашааны урт	0	20 км		Хилийн цэргийн 6 анги (0101, 0130, 0132, 0214, 0275, 0285)-ийн хариуцсан хэсэгт 26.9 км, 2022 онд 0101 дүгээр ангийн хариуцсан хэсэгт 13.1 км, “Цагаандэл уул” боомтын хэсэгт 3.5 км хэсэгт тус тус хамгаалалтын хашаа шинээр байгуулснаар хэрэгжилтийг 2.1 дахин давуулж биелүүлсэн.
	Шинээр байгуулах дохиоллын системийн урт	0	82 км		Хилийн цэргийн 0245, 0243, 0101 дүгээр ангиудын 7 салбар (Хүдэн, Боршоо, Алтанбулаг,Тавт, Бүргэдэй-Уул, Номт, Худаг-Өндөр)-ын хариуцсан хэсэгт нийт 132.5 км дохиоллын систем суурилуулан 17 ширхэг (PTZ) камер, 2 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан.
	Шинэчлэн засварлах харуулын байрны тоо	0	127		Хилийн цэргийн 10 анги (0130, 0146, 0165, 0184, 0198, 0214, 0245, 0257, 0287, 0311)-ийн 21 хилийн харуулын байранд засвар хийсэн.

2.4.	Хилийн анги, салбаруудыг байнгын цахилгааны эх үүсгүүрт холбох	Төвийн эрчим хүчний системд шинээр холбох ангийн тоо	0	1	Улсын төсөвс	Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн төвийг Говь-Алтай аймгийн Алтай сумын сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрт холбосон.
		Төвийн эрчим хүчний системд шинээр холбох салбарын тоо	0	36	Улсын төсөв	Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн 0154 дүгээр салбар (Гашуунсухайт)-ыг төвлөрсөн эрчим хүчний системд холбосон. Увс аймаг дахь хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Давст”-ын салбарыг 17 км төвлөрсөн эрчим хүчний системд холбохоор шугамын төмөр бетон тулгуурыг суурилуулж, өндөр хүчдэлийн шугамын угсралтыг хийсэн. Дорнод аймгийн Халх гол сум дахь хилийн цэргийн 0198 дугаар ангийн “Дэгээ гол” салбарыг эрчим хүчинд холбох зураг төсвийг батлуулж, ажлын зургийн дагуу 20 км шугамын 310 ширхэг төмөр бетон тулгуурыг босгосон.
		Сэргээгдэх эрчим хүчний системд шинээр холбох салбарын тоо	0	32	Улсын төсөв	Хилийн цэргийн 0303 дугаар ангийн 1, 0286 дугаар ангийн 2, 0287 дугаар ангийн 2, нийт 5 салбарт 5 кВт-ын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр шинээр угсарч, ашиглалтад оруулсан.
		Шинэчлэн засварлах харуулын байрны тоо	0	127	Улсын төсөв	2021 онд 11 анги (0129, 0131, 0132, 0146, 0198, 0184, 0245, 0257, 0275, 0287, 0311)-ийн 28, 2022 онд 10 анги (0130, 0146, 0165, 0184, 0198, 0214, 0245, 0257, 0287, 0311)-ийн 21 хилийн харуулын байранд засвар хийсэн.
Зорилт 3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
3.1.	Орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан “Монгол Улсын хил хамгаалалтын удирдлага төв”-ийг байгуулах	Удирдлагын төв байгуулсан эсэх	0	1	Улсын төсөв	Хил хамгаалах ерөнхий газрын өргөтгөлийг барьж дуусган, “Хил хамгаалалтын удирдлагын төв”-ийг дэвшилтэт техник, технологиор төхөөрөмжлөн, хил хамгаалалтад нэвтрүүлсэн.

3.2.	Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан ухаалаг цахим гарцыг шалган нэвтрүүлэх албанд нэвтрүүлэх	Цахим гарц нэвтрүүлсэн боомтын тоо	0	26	Улсын төсөв	“Цахим гарц”-ыг Чингис хаан” агаарын замын боомтод 8 ширхэг суурилуулж ажиллагаанд оруулан, “Замын-Үүд” авто замын боомтод 10 ширхэгийг суурилуулж, ашиглалтад шилжүүлэхэд бэлэн болгосон. “Алтанбулаг” автозамын боомтод 4 ширхэгийг суурилуулахаар техник хэрэгсэл бэлэн болсон ч боомтын барилгын ажлаас шалтгаалан хүлээгдэж байна. Мэдээллийн санг (postgresql) шинээр хөгжүүлэх ажлыг гүйцэтгэж 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд хилийн боомтуудад бүрэн нэвтрүүлсэн.
3.3.	Хилийн зорилтот боомтын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд хүний биометр мэдээлэлд суурилсан орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах	Техник хэрэгсэл нэвтэрсэн боомтын тоо	1	5	Улсын төсөв	2023 онд Бүгд Найрамдах Франц Улсын “Атермес” компанитай хилийн боомтыг дохиолол, хяналт хамгаалалтын нэгдсэн системд шилжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийг ХХЕГ-ын даргын түвшинд байгуулж, хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Хүдэн”-гийн заставын хариуцсан хэсэг болон “Боршоо” боомтод дохиолол, хяналтын систем суурилуулахад шаардлагатай техник хэрэгслийг худалдан авах асуудлыг шийдвэрлүүлж, “Бодь-электроникс” ХХК-тай мэдрэгч бүхий шилэн кабелийн дохиолол, хяналтын техник хэрэгслийг нийлүүлэх, угсралт, үйлчилгээний гэрээг байгуулж, 52 км шилэн кабелийг татан, “Боршоо” боомтод 12 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан. Хилийн цэргийн 0245, 0243, 0101 дүгээр ангиудын 7 салбар (Хүдэн, Боршоо, Алтанбулаг, Тавт, Бүргэдэй-Уул, Номт, Худаг-Өндөр)-ын хариуцсан хэсэгт нийт 132.5 км дохиоллын систем суурилуулан 17 ширхэг (PTZ) камер, 2

						ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан.
Зорилт 3. Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						
4.1.	Оросын Холбооны Улстай улсын хилийн хоёр дахь удаагийн хамтарсан шалгалт явуулах	Төлөвлөгөөт ажлыг эхлүүлсэн байх	0	1		2022 онд Монгол, Оросын улсын хилийг хамтран шалгах комиссын I хуралдааныг Москва хотод, II хуралдааныг Улаанбаатар хотод зохион байгуулсан зохион байгуулж эрх зүйн үндэслэл, үйл ажиллагаа явуулах зарчмын асуудлыг хэлэлцэн тохиролцож (Хилийг хамтран шалгах хамтарсан комиссын дүрэм, Хил шалгах үед улсын хилийг нэвтрэх журам, Улсын хилийг хилийн тэмдгээр тэмдэглэх загвар, Улсын хилийг хамтран шалгах хамтарсан ажлын хэсгийн заавар) эрх зүйн актуудыг баталсан. 2023 онд Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах Монголын талын хэсгийн дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтарсан “Хээрийн ажлыг зохион байгуулах тухай” 2023 оны мн/05/,мн/02 дугаар тушаал, ажлын хэсгүүдийн 2023 онд хийх ажлын график төлөвлөгөөг гарган ажлыг эхлүүлж, 12 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сургалт явуулан, хилийн төмөр бетонон баганыг байгалийн боржин чулуун баганаар сольж, үндсэн 240, төв жижиг 80, нийт 320 ширхэг баганыг шинээр босгосон. Хамтран шалгах комиссын III, IV хуралдаанд оролцож, хилийн инженерийн төхөөрөмжийн талаар санал солилцсон. 2024 онд Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах, Монгол, Оросын хамтарсан комиссын Монголын талын хээрийн ажлын хэсэг 1620 багана (тэмдэг)-ны 1217 буюу 75.1 хувийг 2023, 2024 онд байгалийн

						чулуун хилийн тэмдгээр шинэчлэн сольж босгосон.
4.2.	4.2.Улсын хил хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хилээр шалган нэвтрүүлэх зэрэг ижил төстэй чиг үүрэг бүхий гадаадын байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаа тогтоох, өргөжүүлэх	Харилцаа, хамтын ажиллагаатай гадаадын байгууллагын тоо	3	6		Хил хамгаалах байгууллагын дээд түвшний ажлын удаагийн уулзалтыг 2021 онд 8 удаа, 2022 онд 6 удаа, 2023 онд 13 удаа, 2024 онд 14 удаа тус тус зохион байгуулж, санамж бичиг байгуулсан. (БНХАУ, ОХУ, АНУ, БНСУ, БНЭУ, Франц, НҮБ)
Зорилт 5. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэтрүүлнэ.						
5.1.	Хилийн хэсэгт шинээр хилийн анги байгуулж, шалган нэвтрүүлэх заставыг өргөтгөн отряд байгуулах	Шинээр байгуулах хилийн ангийн тоо /Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум/0	0	1		Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум дахь хилийн цэргийн анги шинээр байгуулах ажлын төсөв 2024 онд 3,482.0 сая төгрөгийн санхүүжилт авч, барилга угсралт (штаб /спорт заал, соёлын төв/, цэргийн байр, эмнэлэг, зочид буудал, уурын зуух)-ын ажлын гүйцэтгэл дууссан.
		Шинээр байгуулах отрядын тоо /Дорнод аймгийн Чулуун хороот сум/	0	1		Эрээнцавын шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн анги шинээр байгуулах ажил (Дорнод, Чулуунхороот сум)-ын барилга угсралт (штаб, цэргийн байр, тавиулан, уурын зуух, эмнэлэг, зочид буудал, агуулах)-ын ажлын гүйцэтгэл дууссан.
5.2.	Улсын хил хамгаалалтын цэргийн холбоо, мэдээллийн сүлжээ, дохиолол, хяналт, хамгаалалтын систем, зэвсэг, тусгай хэрэгслийг шинэчлэх, тусгай зориулалтын автомашинаар хангах	Цэргийн холбооны шинэчлэлийн хувь	10.3	26.1		Хил хамгаалах байгууллагын радио холбоог 28.5 сая ам.доллараар шинэчлэх төслийг боловсруулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулж, холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Хилийн цэргийн радио холбоог шинэчлэх чиглэлээр төсөв тусгагдаагүй боловч ХЗДХЯ-ны харьяа “Төрийн цэргийн болон хууль сахиулах

					байгууллагуудын радио холбоог шинэчлэх” төслийн хүрээнд АНУ-ын Засгийн газар болон “Моторола” компанитай төслийн I шат (Улаанбаатар хүрээний радио холбооны дэд бүтцийг байгуулах)-ны гэрээг 2023 оны 12 дугаар сард байгуулах, суурилуулалтын ажлыг 2024 оны II улиралд багтаан хэрэгжүүлж эхлэхээр тохиролцсон. 2024 онд Хилийн цэргийн 0130, 0165, 0184, 0243, 0245, 0285, 0287, 0306 дугаар ангиудын радио холбооны дахин дамжуулагчийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил удирдлагын шийдвэрээр хойшилсон.
		Хилийн боомтуудын дохиолол, хяналт, хамгаалалтын системийн шинэчлэлийн хувь	11.5	33.0	2023 онд Бүгд Найрамдах Франц Улсын “Атермес” компанитай хилийн боомтыг дохиолол, хяналт хамгаалалтын нэгдсэн системд шилжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийг ХХЕГ-ын даргын түвшинд байгуулж, хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Хүдэн”-гийн заставын хариуцсан хэсэг болон “Боршоо” боомтод дохиолол, хяналтын систем суурилуулахад шаардлагатай техник хэрэгслийг худалдан авах асуудлыг шийдвэрлүүлж, “Бодь-электроникс” ХХК-тай мэдрэгч бүхий шилэн кабелийн дохиолол, хяналтын техник хэрэгслийг нийлүүлэх, угсралт, үйлчилгээний гэрээг байгуулж, 52 км шилэн кабелийг татан, “Боршоо” боомтод 12 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан. Хилийн цэргийн 0245, 0243, 0101 дүгээр ангиудын 7 салбар (Хүдэн, Боршоо, Алтанбулаг,Тавт, Бүргэдэй-Уул, Номт, Худаг-Өндөр)-ын хариуцсан хэсэгт нийт 132.5 км дохиоллын систем суурилуулан 17 ширхэг (PTZ)

						камер, 2 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, ажиллагаанд оруулсан.
		Зэвсэг тусгай хэрэгслийн шинэчлэлийн хувь	25.0	43.0		“LEUPOLD BX MCKENZIE HD 10x42” загварын дуран 433 ширхэг, “LEUPOLD BX MCKENZIE HD 8x42” загварын дуран 214 ширхэг, “PULSAR ACCOLADE 2 LRF PRO” загварын дулаан мэдрэгчтэй дуран 15 ширхэг, “FENIX TK26R TACTICAL FLASHLIGHT” загварын гар чийдэн 30 ширхэг, “HOWARD IMPACT” загварын буудлагын чихэвч 30 ширхэг, 10 төрлийн 507 ширхэг тусгай хэрэгслээр хилийн цэргийн анги, тусгай салбар, боомтуудыг хангасан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 8 төрлийн 800 ширхэг тусгай хэрэгслийг хүлээн авч, хилийн цэргийн 0303 дугаар ангийг хангасан. 2024 онд хилийн цэргийн анги, салбаруудад 2 нэр төрлийн буудлагын зэвсэг, 3 нэр төрлийн галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, 6 нэр төрлийн 600 ширхэг тусгай хэрэгслээр хангасан.
		Тусгай зориулалтын авто техникийн шинэчлэлийн хувь	6.8	24.0		БНХАУ-ын “Ардын чөлөөлөх арми”-аас буцалтгүй тусламжаар олгосон дунд, бага оврын 24 автобусыг хүлээн авч, хилийн цэргийн ангиудад хангасан. Улсын хил хамгаалалтад ашиглах 2 дугуйт 385 нэгж мотоцикл, туулах чадвар сайтай суудлын “Ниссан Патрол Y61 GRX” загварын 14 нэгж, ачаа тээврийн зориулалттай “FAW” загварын 30 нэгж, нийт 429 нэгж автомашин техник худалдан авч, хилийн цэргийн ангиудад хангасан. “Ниссан Патрол Y61” загварын 1, “Ниссан навара” загварын 101, нийт 102 нэгж

						автомашинаар хилийн цэргийн салбаруудын автопарк шинэчлэлийг 100 хувьд хүргэсэн. Суудлын 14 нэгж, туулай чадвар сайтай 24 нэгж, хүн тээврийн 36 нэгж, ачааны 12 нэгж, завь, хөнгөн хөлөг 8 нэгж, 4 дугуйт мотоцикл 37 нэгж, нийт 19 нэр төрлийн 131 нэгж автомашин техникийг хилийн цэргийн ангиудад хангасан. Тусгай зориулалтын авто техникийн шинэчлэлийг 4 дугуйт (UTV) 18 нэгж, Kubota 1 нэгж, нийт 19 нэгж техникийг худалдан авсан. ОХУ-д үйлдвэрлэгдсэн “Север-650к”, “Север-650к1” загварын аерлодка (цас, усны явагч, хөнгөн хөлөг)-оор хилийн цэргийн 0306 дугаар ангийг хангасан. “Вранглер” загварын 2, “Ланд Круйзер-78” загварын 5 нэгж автомашин, “Фрагет-430 JT”, “Фрагет-480 JT” загварын 5 нэгж хөнгөн моторт завь, нийт 12 нэгж тусгай зориулалтын техникийг худалдан авч, хилийн цэргийн 0303 дугаар ангийг хангасан. 2024 онд тусгай зориулалтын 7 нэгж буюу "Lovol-1804" загварын 3 нэгж трактор, "SD65E" загварын 2 нэгж дунд оврын эксковатор, "ZS090V" загварын 1 нэгж бобкат трактор, "LX-2000" загварын 1 нэгж замын индүү худалдан авч хилийн цэргийн ангиудад хангасан.
Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх						
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
1.1	Хорих байгууллагыг бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлэх	2 дугаар шатлалын эмнэлгийн	2	3		401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт 14 нэр төрлийн 235.942.000, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид 17 нэр төрлийн

		тусламж, үйлчилгээг үзүүлэх нэгжийн тоо				135.168.000 төгрөгийн, 437 дугаар нээлттэй хорих ангийн эмнэлгийн хэсэгт Орхон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 24 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн эмнэлгийн хэсэг нь 1.400.000 төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг тоног төхөөрөмжийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан худалдаж авсан байна. 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт Глобал сангийн төслийн хүрээнд агааржуулалтын 500.000 төгрөгийн үнэ бүхий системийг суурилуулсан боловч цахилгааны хүчдэл хүрэлцэхгүйн улмаас ашиглалтад оруулаагүй байна. “Пиурли таур” ХХК-ны цахилгааны инженерийн ажилчид хорих ангийн цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.
		Нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх байрны тоо	0	4		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 413, 415, 419, 437, 439, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Өмнөговь, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Өмнөговь аймгийн Ханбогд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст “Хоригдлыг суллахад бэлтгэх байр”-ыг шинээр байгуулахад шаардлагатай нийт 198,500,000 төгрөгийг шийдвэрлэсэн. “Хоригдлыг суллахад бэлтгэх өрөө”-г 407, 409, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд ашиглалтад оруулсан.

						Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2024 онд дотоод орлогоос 42,825,750 төгрөгийн зардлаар 8*10 буюу 80м2 3 өрөө “Суллагдахад бэлтгэх байр”-ийг шинээр барьж, ашиглалтад оруулсан. Хорих анги, байгууллагын хэмжээнд “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн дагуу нийт 4002 хоригдлыг сургалтад хамруулан, суллагдсан 239 иргэнийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажлын байранд зуучлан нийгэмд бие даан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.
		Төв орон нутгийн хорих анги, байгууллагад ял шийтгэгдсэн орон нутагт нь ялыг эдлүүлж байгаа хоригдлын тоо	30	40		Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл нь 2023-2024 оны жилийн эцсийн байдлаар 81 удаагийн хуралдаанаар нээлттэй хорих ангид 4604, хаалттай хорих ангид 286, эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай ангид 444, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад өсвөр насны хүн 112, нийт 5446 хоригдол хуваарилсан.
1.2.	Орон нутаг дахь цагдан хорих байрыг шинээр барих	Шинээр барьсан цагдан хорих байрны тоо	0	8		Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн албан контор, цагдан хорих байрны барилгыг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтанд оруулсан. Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын “Нэг цонхны үйлчилгээ бүхий цагдан хорих байр”-ны барилгыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ББҚД-41/2024 дугаар бүхий комиссын дүгнэлтээр хүлээн авч, бүрэн ашиглалтад оруулсан.

						Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилгыг орон нутгийн төсвөөр барихаар зураг төсөл хийгдэж 2024 онд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд барилгын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлүүлж, өнөөдрийн байдлаар барилгын суурь болон 4 давхар карказын цутгалтыг хийсэн. Барилгын ажлын явц 48 хувьтай байна.
1.3.	Орон нутаг дахь баривчлах байрыг барьж, ашиглалтад оруулах, шинэчлэн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Шинээр барьсан баривчлах байрны тоо	0	15		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь дотоод нөөц бололцоондоо тулгуурлан хуулиар тогтоосон шаардлага, стандартад нийцүүлэх баривчлах байрыг өргөтгөн засварлан тохижуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж 2021 онд Булган, Дорнод, Дундговь, Орхон, Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд баривчлах байр хүлээн авсан. 14 аймагт баривчлах байрыг үе шаттайгаар шинээр барихаар төлөвлөн ажиллаж байна. Цаашид бусад орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шаардлагатай алба хаагчийн орон тоо болон өргөтгөл засвар, тохижилт хийхэд шаардагдах төсөв, санхүүгийн талаар судалж, 2024 оны 03 дугаар сард албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан.
		Засвар хийсэн байрын тоо	0	6		Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих анги 58.0 сая төгрөгөөр, Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 38.0 сая төгрөгөөр, 435 дугаар хаалттай хорих анги хоригдлын байрны их засварын ажилд 130,0 сая төгрөгөөр, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги хоригдлын

					байрны засвар 139,7 сая төгрөгөөр, 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги хоригдлын байрны тээврийн их засвар 106,3 сая төгрөгөөр, 433 анги гурлын үйлдвэрийн тээврийн засвар 81,4 сая төгрөгөөр, 407 дугаар нээлттэй, хаалттай анги нярай байрны их засвар 90,0 сая төгрөгөөр, 405 дугаар хаалттай хорих анги хоригдлын байрны их засвар 308,0 сая төгрөгөөр, төр хур нөхөн сэргээх сувилал гадна дотор сантехникийн их засвар 42,9 сая төгрөгөөр, хуяглэн хүргэлтийн тээврийн хэрэгслийн 3,000,0 сая төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжилт хийсэн. 2024 онд мөн нийслэлийн санхүүжилтээр гүйцэтгэх ажлын тээврийн хэрэгсэл 2500,0 сая төгрөгөөр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авах байрыг засварлан тохижуулсан.
1.4.	Хорих ял шийтгэгдсэн өсвөр насны хүнийг нийгмээс тусгаарлан нийгэмшүүлэх цогцолбор байгууламж барих	Байгууламж баригдсан эсэх	0	1	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын сургуулийн барилгыг барихад шаардлагатай 6,100,000,000 (зургаан тэрбум нэг зуун сая) төгрөгийг улсын төсөвт суулгасан. 2024 онд 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн улсын төсвөөс гаргуулахаар батлуулсан. Уг тендерт шалгарсан “Барилга эрч” ХХК нь 2024 онд барилга угсралтын ажлын гэрээ байгуулсан бөгөөд гэрээ байгуулснаас хойш сургууль, заалны барилгуудын суурийн нүх ухаж, бетон бэлтгэлийг цутгаж, аяган суурийн 1 дүгээр шатлалын 40 ширхэг, 2 дугаар шатлалын 16 ширхэг хэвийг тус тус бэлтгэсэн. Мөн гүйцэтгэгч компаниас 2024 оны 10 дугаар сарын 21-ний

						өдрөөс барилгын ажлыг зогсоож, 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс үргэлжлүүлэхээр хүсэлт ирүүлээд байна.
1.5.	Пробацийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбогдсон суурь судалгааг хийж, хэрэгжүүлэх санал боловсруулах	Хэсэгчилсэн болон хавсарга судалгааны тайлан	0	2		Хуулиар хүлээсэн чиг үүргийг нэг мөр хэрэгжүүлэх, хэрэгжилтийг боловсронгуй болгоход тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх зорилгоор Дотоод хэргийн их сургуультай хамтран “Албадан эмчлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Уг хуралд Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар, Сэтгэцийн Эрүүл мэндийн Үндэсний төв, Дотоод хэргийн их сургууль, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарын төлөөлөл 100 гаруй алба хаагч, эрдэмтэн, судлаачид оролцож, 6 илтгэл хэлэлцүүлэн, санал солилцлоо. Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг зөвлөмж болгон гаргаж, илтгэлүүдийг эмхэтгэл болгон гаргасан.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж байгаа цахим хяналтын системд шинэчлэлт хийх	Цахим хяналтын систем нэвтэрсэн эсэх	1	2		Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргын тушаалаар 16.941 ам.долларын “Бараа нийлүүлэх гэрээ”-г БНХАУ-ын “Shenzhen Hexion Technology Co.,LTD” компанитай байгуулж, 150 ширхэг, тэдгээрийн дагалдах хэрэгслийг хүлээн авсан.

						БИ ТИ ЖИ ТИ ХХК-тай 2024 оны 197.830.000 (Нэг зуун ерэн долоон сая найман зуун гучин мянга) төгрөгийн цахим бугуйвч, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээг байгуулж, 2024 онд DDХ04 загварын цахим бугуйвчийн зөөврийн цэнэглэгч 500, батарей 80, түгжээний лац 500, J-link төхөөрөмж 5, R12W загварын цахим бугуйвчийн оосор 350 ширхэг, дэлгэц 150 ширхэг, батарей 350 ширхэг, соронзон цэнэглэгч 400, зөөврийн цэнэглэгч 900 ширхэг нийт 197.830.000 төгрөгийн дагалдах хэрэгслийн акт үйлдэж хүлээн авсан. Мөн тус шалгарсан “БИ ТИ ЖИ ТИ” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр “№84 дугаар 525.000.000 /таван зуун хорин таван сая/ төгрөгийн гэрээг байгуулсан. Гэрээний дагуу 310 ширхэг, РТ880 загварын 290 ширхэгийг 2 үе шаттайгаар буюу нийт 600 ширхэг хяналтын цахим бугуйвчийг хүлээн авсан. 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр “Юнител” ХХК-аас зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглагдах цахим бугуйвчид шаардлагатай 600 ширхэг дата дугаар авсан. Эвдэрч гэмтсэн талаарх дүгнэлт гарсан, баталгаат хугацаа дууссан, цаашид засаж, сэлбэн ашиглах боломжгүй болсон 711 ширхэг 556.073.100 (Таван зуун тавин зургаан сая далан гурван мянга нэг зуу) төгрөгийн үнэ бүхий цахим бугуйвчийг 2024 оны 09 дүгээр сард акталсан.
2.2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх	Хоригдлын биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын	0	1		Азийн хөгжлийн банкны 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах “Legal Compliance Monitoring system”-г боловсронгуй болгох төслийн хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг

		системийг нэвтрүүлсэн эсэх				сайжруулах, системийг хөгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023 онд зарлагдсан тендерт мэдээлэл технологийн “IT Zone” ХХК шалгарсан. Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс “Ажлын даалгавар”, шаардлагатай мэдээллийг өгч, тус компани нь систем, программыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Мөн “IT Zone” ХХК-тай “Legal Compliance Monitoring system” төслийн эхний тайлан /inception report/-г баталгаажуулах ажлын хүрээнд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний нэгдсэн системийн дэлгэцийн зураг, мэдээ судалгаа, баталгааны маягт, төслийн дагуу суурилуулах тоног төхөөрөмжийг баталгаажуулсан.
		Байгууллагын үйл ажиллагаанд тоон радио холбооны технологийг нэвтрүүлсэн эсэх	0	1		“Моторола сольюшн” компанийн төлөөлөгчид 2023 оны 11 дүгээр сарын 07, 08-ний өдрүүдэд Монгол Улсад зочилж, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэд сайдтай хийсэн уулзалтын үеэр буцалтгүй тусламжийн гэрээ байгуулж, 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тоног төхөөрөмжүүд Монгол Улсад ирүүлэх, угсралт суурилуулалтыг 2 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан байсан боловч 2025 онд эцэслэн шийдвэрлэгдэх талаар мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн.
Зорилт 3.Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						
3.1.	Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх	Хамтын ажиллагаатай улс орны тоо	10	15		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Япон, Солонгос, Оросын Холбооны Улс, Сингапур, Австрали, Хятад, Чех, Польш, Герман, Канад, Финланд, Эстони, Хонк-Конг, Турк, Гүрж, Энэтхэг, Вьетнам зэрэг нийт 17 гадаад улс орны ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцаа тогтоон

						хорих ял эдлүүлэх ажиллагаа, пробацийн тогтолцоо /хорихоос өөр төрлийн ял эдүүлэх ажиллагаа/, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлсэн.
Зорилт 4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.						
4.1.	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн эсэх	0	1		Тус ажлын хүрээнд дунд хугацааны 4 төрлийн хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021.03.23-ны өдрийн А/43 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021.03.23-ны өдрийн А/42 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хөгжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021.03.23-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийн 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021.06.21-ний өдрийн А/97 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим архивын үйл ажиллагааг

						эрчимжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр” зэрэг болно.
4.2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор цогц арга хэмжээ авах	Байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх хувь	60	100		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативийн дагуу байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэн, захиргаа, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэг мөр хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-т заасны дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсөлд тус байгууллагын орон тоог 1055 орон тоогоор нэмэгдүүлэх саналыг тусган боловсруулж, 2026-2027 оны төсвийн төсөөллийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/1780 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 223 орон тоог шийдвэрлүүлсэн.
4.3.	Хорих ангийн үйлдвэрлэлийг өргөжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх	Нийт хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн хувь	60	65		Байгууллагын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын байдлаар аж ахуй үйлчилгээнд 3748, гэрээт хэсэгт 1413, хувцас, гутал, нэхмэл, эсгий, оёдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 285, тавилга болон бусад мод бэлтгэл, гэр, гэрийн мод, модон эдлэлийн үйлдвэрлэлд 412, төмөр хийцийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 33, газар тариалан эрхлэлтэд 58, мал, аж ахуй эрхлэлтэд 92, гурилын үйлдвэрлэлд 10, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 195, барилга, орон сууц 25, чулуу бэлтэл, чулуун бүтээгдэхүүн, замаска, блок үйлдвэрлэлд 43, авто засвар бусад үйлчилгээнд 17 нийт 6331 хоригдлыг хөдөлмөрөөр хангаж, цалин хөлснөөс гэм хорын төлбөрт 2021 төлбөр 187.0 сая төгрөг, 2022 он

						339,4 сая төгрөг, 2023 он 510,5 сая төгрөг, 2024 он 614,3 сая төгрөг нийт 1,651.2 сая төгрөгийг барагдуулсан байна.
		Үйлдвэрлэлийн ажиллах хүчин чадлыг нэмэгдүүлэх	50	60		Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн тоосгоны үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэхээр төлөвлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авч, угсарч, суурилуулсан. 433 дугаар хаалттай хорих ангид гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулсан. 441 дүгээр нээлттэй хорих ангид төмөр торны үйлдвэрийг өргөжүүлэхээр тендер зарлаж, “Голден Хоул” ХХК-тай трактор, нүхтэй торны тоног төхөөрөмж, өргөст торны тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/257 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хорих анги, салбар нэгжүүд 2024 оны байдлаар 4,905,5 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүн борлуулалтын 14,025,7 тэр бум төгрөгийг хуримтлуулж борлуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлээд байна.
4.4	Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыгхангах, учирч болзошгүй эрсдэлийг	Хамгаалалтын алба хаагчдын хувь	20	80		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 59 хорих анги байгууллагын цагдан хорих чиглэлээр 9.8 хувийг эрэгтэй, 0.4 хувийг эмэгтэй алба хаагч, харуул хамгаалалтын чиглэлээр 29.2 хувийг

бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх					эрэгтэй, 5.9 хувийг эмэгтэй алба хаагч байгаа нь нийт алба хаагчдын 45.5 хувийг эзэлж байна.
	Аюулгүй байдлыг хангах ажиллагаанд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хувь	22	60		Хорих анги байгууллагад энгэрийн камер 174, гар станц 540 /холбоо дохиоллоос тодруул/, гарын гав 800, гар, хөлийн гав 192, резинэн бороохой 377, цахилгаан бороохой 163, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хий 81, агсамж 116, бамбай 168, хамгаалалтын дуулга 168, хутганаас хамгаалах хантааз 1097, Өвдөгний хамгаалалт 81, тохойн хамгаалалт 57, хутганаас хамгаалах бээлий 44 ширхэг харуул хамгаалалтын алба хаагчдын 18.7 хувь нь нэг бүрийн тусгай хэрэгслээр хангагдсан. Цаашид байгууллагын хэмжээнд харуул хамгаалалтын алба хаагчдыг хүн нэг бүрийн тусгай хэрэгслээр хангахад 14 нэр төрлийн энгэрийн камер 554, хэт богино долгионы гар станц 730, гарын гав 910, гар хөлийн гав 272, резинэн бороохой 601, цахилгаан бороохой 814, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хий 666, агсамж 385, бамбай 504, хамгаалалтын дуулга 335, хутганаас хамгаалах хантааз 110, өвдөгний хамгаалалт 255, тохойн хамгаалалт 241, хутганаас хамгаалах бээлий 110 ширхэг буюу нийт 6487 ширхэг тусгай хэрэгсэл шаардлагатай байна.
	Байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа автомашины парк шинэчлэлийн хувь	30	65		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд тусгай зориулалтын автомашин альфард 2 ширхэг, фургон 30 ширхэг, маяти 4 ширхэг, суудлын автомашин 10 ширхэгийг тус тус худалдан авсан.
Дөрөв. Шүүхийн шинжилгээ хийх					

Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.

1.1.	Шүүхийн шинжилгээний албадын лабораторийн барилгыг барьж, хүний нөөц, хэрэгцээт техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх	Орон нутагт барьсан шүүхийн шинжилгээний лабораторийн тоо	3	18	Шүүх шинжилгээний тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсэгт “Шинжилгээний байгууллагыг нутаг дэвсгэрийн, эсхүл тойргийн зарчмаар байгуулж болно” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 182 дугаар тогтоолоор “Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд” аймагт бүсийн Шүүх шинжилгээний төвүүдийг байгуулахаар шийдвэрлэж, Дорнод аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвийг 2023 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулсан. Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв 690,0 сая төгрөг, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв 590,0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 2,489.2 сая төгрөгөөр тус тус стандартын шаардлагад нийцсэн нэг загварын лабораторийн зориулалт бүхий барилгыг бариулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Сэлэнгэ аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн санхүүжилт шийдэгдээгүй тул зарим аймгуудын шүүх шинжилгээний нэгжийн байрны асуудлыг балансаас балансад шилжүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын дагуу Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн байрыг тус байгууллагын мэдэлд балансаас балансад шилжүүлэн авсан.
------	--	---	---	----	--

						Увс аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс Аймгийн засаг даргын 2023 оны А/249 тоот захирамжаар 1358м² газрыг балансаас балансад албан зориулалтаар 9 жилийн хугацаатай Улсын бүртгэлийн Э-1520002354 дугаартай эзэмших эрхийн гэрчилгээг авсан. Хэнтий аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс 0,15 га газрын Э-1817000221 улсын бүртгэлийн дугаартай гэрчилгээ авсан. Ховд, Өвөрхангай аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Булган, Говь-Алтай, Орхон, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Увс, Завхан, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгийн шүүх шинжилгээний хэлтсүүдэд лабораторийн нэг загварын лабораторийн байр бариулахаар нийт 40.8 тэрбум төгрөгийн саналыг 2024 оны 01/3684 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны төсвийн хязгаарын саналд тусгуулахаар хүргүүлсэн.
1.2.	Шүүх эмнэлгийн лабораторийн болон цогцос хадгалах зориулалтын барилгыг барих	Шүүх эмнэлгийн лабораторийн болон цогцос хадгалах зориулалтын барилгын тоо	1	2		Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газрын агентлаг Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны санг төлөөлж БНСУ-ын Экспорт-Импорт банк хоорондын “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийн 18,735,000 ам.долларын зээлийн гэрээг 2021 онд байгуулж, Нийслэлийн баруун талд Шүүх анагаах ухааны шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг барихаар төлөвлөн, техник эдийн засгийн үзүүлэлтийг хийсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/162 (А/143) дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, төсөлд зөвлөх үйлчилгээ

					үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 онд зарлаж, 2023 онд БНСУ-ын “Аум энд Лий Архитектур энд Ассецаци” ХХК шалгарч, 2023 онд 3,212,000 ам.долларын гэрээг байгуулж, гэрээний дагуу 2023 онд 642,400 ам.долларыг санхүүжилсэн. 2024 онд улсын төсвөөс санхүүжилтийн зардал тусгагдаагүй боловч холбогдох төрийн байгууллагатай хамтран дараах ажлуудыг хийсэн. Тухайлбал, Хот байгуулалт, хөгжлийн газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 1 дүгээр сарын 05-ны хурлаар архитектур төлөвлөлтийн даалгаврыг хэлэлцүүлж, 2019 онд батлагдсан барилгажих талбайг томсгож, шинэчилсэн. Төсөл хэрэгжих талбайд инженер геологийн судалгааг хийлгэх 11.7 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн сайдын багцаас шийдвэрлүүлэн “Монгео Экотех” ХХК-аар хийлгэсэн. Төсөл хэрэгжих газрын тогтоц, жалга нь барилга барихад хүндрэл учруулж болзошгүй байсан тул "Жаргалантын амны үерийн далангийн ажил Суваг-1" хөтөлбөрийн хүрээнд Геодози, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ жалгыг шилжүүлсэн. Улаанбаатар хотын зүүн талд Шүүх анагаах ухааны шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилга барих газрын асуудлыг шийдвэрлэхээр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Далан давхар (Самбалхүндэв)-ийн оршуулгын газрын 10 га талбайг чөлөөлж, нөхөн сэргээлт хийсний үндсэн дээр 1 га газрыг
--	--	--	--	--	---

						барилга барих зориулалтаар тус байгууллагад 2024 оын 8 дугаар сарын 14-ны өдөр шилжүүлж, газрын Э-2202011605 тоот гэрчилгээ авсан.
1.3.	Шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээний орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах	Техник, тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	0	1	Бадам-Очир	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны санхүүжилтээр 2021 онд “Chison Ebit-30” загварын зөөврийн хэт авиан шинжилгээний 3 аппарат худалдан авч, хүний биеийн хэвлийн гэмтлийг оношлох, жирэмсэн болон жирэмслэлт таслагдсан эсэхийг тогтоох, мөн ял эдлэхээс чөлөөлөх өвчний жагсаалтад хамаарах эсэх шинжилгээнд онош бататгах зорилгоор ашиглаж байна. Нас барагсдын нас барсан шалтгааныг шүүхийн шинжилгээгээр нарийвчлан тогтоох техник, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох зорилгоор “Мехатроник” ХХК-тай 92.0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт “Зөөврийн дижитал рентген аппарат”-ыг хүлээн авч, шинжилгээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд холбогдох баримт бичгийг боловсруулан, цацрагийн хамгаалалтын хормогч, дозиметр, хувийн хамгаалах хэрэгслийг худалдан авч, Боловсрол, шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газарт хүргүүлсний үр дүнд 2024 оны “24/2-010-161” гэрчилгээний дугаартай “Эрүүл мэндийн чиглэлээр рентген аппарат ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл”-ийг хүлээн авсан.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	ДНХ-ийн нэгдсэн сан бий болгоход шаардлагатай иж бүрэн техник , тоног	ДНХ-ийн нэгдсэн сан бий болсон эсэх	0	1		Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж гэмт хэрэгтнийг нотлон тогтоох болон санг бүрдүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ДНХ-ийн мэдээллийн

	төхөөрөмж, программ хангамж, урвалж, бодис, хэрэгслийг худалдан авах				сангийн “Mondis” хайлтын системийг хийсэн. Уг хайлтын систем нь “Иргэн”, “Ялтан”, “Гэмт хэрэг”, “Илрээгүй гэмт хэрэг” гэсэн үндсэн 4 ангилалтай бөгөөд ангилал тус бүрээр хайлт хийх, мэдээлэл оруулах, цаашид хөгжүүлэлт хийх боломжтой бөгөөд тус хайлтын системд нийт 8000 гаруй ДНХ-ийн мэдээллийг оруулж бүртгэсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран хорих ангид ял эдэлж байсан хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл хүн, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 10000 орчим хүнээс генетикийн дээж авч хадгалсан. БНСУ-ын “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2023 онд ДНХ-ийн шинжилгээний лабораторид 26 төрлийн 66 ширхэг тоног төхөөрөмж, 34 төрлийн урвалж бодис, 12 төрлийн туслах хэрэглэгдэхүүнийг суурилуулж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн бөгөөд үүний үр дүнд Монгол улсад анх удаа санд бүртгэгдсэн ясанд ДНХ-ийн шинжилгээ хийж, эзэнгүй 2 хэргийн хохирогчийг нотлон ажилласан. ДНХ-ийн генетик мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд 2024 онд “ЮУКОМ ГРУПП” ХХК-тай 796.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, БНТУ “Verisis” Со-ний “CLIMS” программ хангамжийн системийн “4.11.4.3” хувилбарыг суурилуулж эхний ээлжид 815 дээжид туршилт тохируулгыг хийж, ДНХ-ийн мэдээллийг санд оруулсан бөгөөд
--	---	--	--	--	--

					сангийн тохирол, хайлт, магадлалын статистик зэрэг бүх үзүүлэлтүүд хэвийн ажиллаж эхэлсэн. Ингэснээр ДНХ-ийн шинжилгээгээр эцэг, эх байх магадлалыг тооцож >99.99% байх магадлал, хүн амд тухайн генетик профайл дахин давтагдах магадлал, геномын ДНХ-ийг ялгах, ялгарсан ДНХ-ийн агууламж, задрал, дээжид агуулагдаж буй эрэгтэй, эмэгтэй ДНХ-ийн ялгааг тогтоох зориулалт бүхий “real-time PCR”-ийн үр дүнг тооцон, сан бүрдүүлэх боломж бүрдсэн.
2.2.	“E-Nifs” улсын хэмжээний нэгдсэн системийг сайжруулах	Системийн хөгжүүлэлтийн хувь	70	100	Нийслэл, орон нутгийн шинжилгээний нэгжүүдийг холбосон “Шинжилгээний бүртгэл мэдээлэл, лавлагааны улсын хэмжээний нэгдсэн систем”-ийг 18,0 сая төгрөгөөр “Их монгол масс медиа” ХХК-аар хийлгэж Үндэсний дата төв дээр дата бааз /сервер/-ыг байршуулсан. Цахим шилжилт рүү орж байгаатай холбогдуулан “E-Nifs” цахим системд тулгуурлан албан хаагчдад зориулж гар утасны “E-nifs 1.0” аппликейшныг хийж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд тус байгууллагын албан хаагчид байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, сургалтын видео хичээл болон цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай авах нөхцөл бүрдсэн. Мөн “E-Nifs” системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн баяжилттай холбоотойгоор “Саммит компьютер технологи” ХХК-аас 17,9 сая төгрөгөөр сервер компьютер худалдан авсан. “Шүүх шинжилгээний үйл ажиллагааны цахим систем”-ийн системийн шаардлага тодорхойлох техникийн бичиг баримтыг 2023 онд 8.8 сая

					төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "Логик солюшн" ХХК-аар хийлгэсэн. Шүүх шинжилгээний тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт "Шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан шинжээч, эсхүл шинжээчдийн багт хуваарилна" гэж заасны дагуу 2023 онд байгууллагын "E-Nifs" нэгдсэн системийг хөгжүүлэн, шинжээч томилох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг шинжээчид цахимаар хуваарилж эхэлсэн. Шинжилгээний цахим бүртгэлийн системд ашиглагдах Poweredge R740 серверийг худалдан авсан бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод сүлжээнд ашиглагдах outlook, lync цахим системийг Poweredge R750xs серверт суурилуулан тохиргоо хийж алба хаагчдыг холбон дотоод сүлжээгээр мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн 2024 онд цахим автомат хуваарилалтын https://172.16.0.15/systemowner системд 2023 онд хуваарилагдсан нийт шинжилгээнүүдийн баазыг цахим аюулгүй байдлын хүрээнд backup хийх буюу нөөцөлсөн.
Зорилт 3.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.					
3.1.	Байгаль орчны бохирдол, хохирлын хэмжээг тодорхойлох экологийн шинжилгээг нэвтрүүлэх	Байгаль орчны бохирдол, хохирлын хэмжээг тодорхойлох экологийн	0	30	Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2020 оны А/216 дугаар тушаалаар Криминалистикийн шинжилгээний газрын харьяанд "Экологийн шинжилгээний лаборатори"-ийг шинээр байгуулж, 6 шинжээчийг томилсон бөгөөд мөн Сайдын 2022 оны А/140 дүгээр тушаалаар

		шинжилгээг нэвтрүүлсэн хувь			Экологийн шинжилгээний лабораторийг бие даасан нэгж болгож, аймаг, орон нутгийг бүсчлэн хариуцах 8 шинжээчийн орон тоог шийдвэрлүүлсэн. 2023 онд Дорнод, Ховд, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Баянхонгор аймгийн шүүх шинжилгээний хэлтэст нийт 4 шинжээч, 2024 онд Нийслэлийн шүүх шинжилгээний газарт, Дархан-Уул, Өвөрхангай аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, Архангай аймгийн шүүх шинжилгээний хэлтэст нийт 6 шинжээчийг тус тус томилсон. 2021 онд 2, 2022 онд 92, 2023 онд 247 шинжилгээ, 2024 онд 310 шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, хүрээлэн буй орчны шинжилгээний чиглэлээр 2022 онд 13,872,847,176 төгрөг, 2023 онд 4,727,512,207.84 төгрөг, 2024 онд 25,074,382,944 төгрөгийн экологи, эдийн засгийн үнэлгээ, хохирлын хэмжээг тогтоосон. Техник, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх ажлын хүрээнд 2022 онд “Киа Моторс” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж БНСУ-д үйлдвэрлэсэн “Киа Вонго 2700” маркийн бүрэн тоноглогсон 167.0 сая төгрөгийн автомашин, шинжилгээний лабораторийн багаж техник хэрэгсэл 643.0 сая төгрөгөөр, мөн үзлэг, шинжилгээ хийхэд шаардлагатай 216.2 сая төгрөгийн өртөг бүхий нийт 23 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийг, 2023 онд 23.3 сая төгрөгийн багаж, хэрэгслийг худалдан авахаас гадна тус шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн судалгааг гарган Байгаль орчин, уур
--	--	-----------------------------------	--	--	---

					амьсгалын санд хүргүүлэн 17,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Мөн 2024 онд 14.5 сая төгрөгийн “RMT-202A Rotary Microtome” багаж тоног төхөөрөмжийг, 3.0 сая төгрөгийн амьтан ургамлын дээж хадгалах шүүгээг тус тус шийдвэрлэсэн. “Экологийн шинжилгээний нэгдсэн сангийн журам”-ын дагуу 2023 онд аймгийн шүүх шинжилгээний хэлтсээс ирүүлсэн 2 зүйл амьтны дээжийг санд авсан бол 2024 онд 1 тооны цоохор ирвэс (үхсэн) ирүүлсэн.
3.2.	Шүүх эмнэлгийн эд эсийн /иммуногистохимийн/ шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Хүчин чадлын хувь	70	100	Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын гистологийн шинжилгээний лабораторийг өргөжүүлж Иммуногистохимийн шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахаар “Синапс” ХХК-тай гэрээ байгуулан “Халдвар хамгаалалтын ариутгалын хаалга”, “Biobase” загварын иммуногистохимийн бэлдэц бэлдэх зориулалттай сорогч болон ариутгагчтай био аюулгүйн шүүгээ, “Bel photonics” загварын гэрлийн 2 микроскоп, “Dpette” загварын электрон гар пипетик”, “Biobase” загварын эмнэлгийн зориулалттай хөргөгчийг 38,388,900 төгрөгөөр худалдан авсан. Үүний үр дүнд гавал тархины гэмтлийн цаг хугацааг нарийвчлан тогтоох, зарим төрлийн амьсгал бүтэлтийг ялган оношлох зэрэг нарийвчилсан шинжилгээг хийх боломжтой болсон. Мөн 2023 онд иммунногистохимийн будгийг шинээр нэвтрүүлж, БНХАУ-д үйлдвэрлэсэн “Биомед” микроскоп 2 ширхэг, “RoundFin” микротом, лаан, тосон цутгамал, шинжилгээний суурь урвалжууд, “S100” будаг зэргийг хүлээн авч

					үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.Түүнчлэн 2024 онд “Biobase” компанийн “BSC-1100IIA2-X” загварын 1 ширхэг, “EA2-5F” загварын сорох шүүгээ 2 ширхэг, “Dakewe DP360” бүрэн автомат будгийн дамжлагын аппарат, “Olympus CX33” дэлгэцтэй дижитал микроскопи, шилэн бэлдэц хадгалах 240000 слайдын багтаамжтай шүүгээ, лаан блок хадгалах 28800 кассетны багтаамжтай шүүгээ зэрэг нийт 197.1 сая төгрөгийн багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглахаас гадна тус лабораторийн зүслэгийн өрөөнд бүрэн засварын ажил хийж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. Дээрх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр эд эсийн (иммуногистохимийн) шинжилгээний эдийн дамжлага сайжирч, хугацаа богиносж, будаг, урвалжийн зарцуулалт багасаж, шинжилгээний үр дүнд ахиц гарч, эдийн шинжилгээний архивын материалыг эвдрэл гэмтэлгүй хадгалах нөхцөл бүрдсэн.
Тав. Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух, гадаадын иргэн, харьяатын асуудлыг эрхлэх					
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг хөгжүүлнэ.					
1.1.	Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт визийн ажилтан томилох	Визийн ажилтан томилсон эсэх	0	4	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/20 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ээр тус агентлагийн Виз, зөвшөөрлийн

					газарт “Хилийн чанад дахь ахлах мэргэжилтэн”-ий 4 орон тоо, цалингийн санг батлуулсан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.4.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдтай зөвшилцөж, Гадаад харилцааны сайд томилох зохицуулалттай зэргээс шалтгаалан 4 орон тооны 2-ыг шийдвэрлэсэн бөгөөд Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газарт ажиллуулж байна. 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийн дагуу Виз, зөвшөөрлийн газарт “Хилийн чанад дахь ахлах мэргэжилтэн”-ий 2 орон тоо, цалингийн санг батлуулсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.4.1-д заасны дагуу Хууль зүй дотоод хэргийн яамтай зөвшилцөн Гадаад харилцааны сайд 2 төрийн жинхэнэ албан хаагчийг БНСУ-ын Сөүл, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод тус тус ажиллуулж байна.
1.2.	Улаанбаатар хотын шинэ нисэх буудалд Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг	Мэдээллийн төвтэй болсон эсэх	0	1	Засгийн газрын 2023 оны 174 дүгээр тогтоолоор “Зорчигчийн мэдээллийн төв”-ийг Хил хамгаалах ерөнхий газрын дэргэд байгуулсан.

	хүлээн авч хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулах					Тухайн байгууллагаас албан хаагчийн цалин хөлс, нэмэгдэл хөлсний санхүүжилт шийдэгдээгүй тул хоёр байгууллага харилцан тохиролцож, байгууллагын даргын 2024 оны Б/71 дүгээр тушаалаар хяналтын 2023 онд ажиллаж байсан улсын байцаагчийг Агаарын замын боомт хариуцсан газарт буцаан томилов.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулах систем нэвтрүүлэх	Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем “goTravel” буюу “API/PNR” үйлчилгээ нэвтэрсэн эсэх	0	1		Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын хилийн хяналт шалгалтыг сайжруулах, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангах, терроризмтой тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын "Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэгч байгууллагаар Хил хамгаалах ерөнхий газрыг тогтоож, хөтөлбөрийн үндэсний зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хариуцуулсны дагуу “goTravel” буюу “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэт систем”-ийг Монгол Улсад нутагшуулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. “Зорчигчийн мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааны чиг үүрэгт тавигдах шаардлага”, зам зураглал, таск листийг үндэслэж төлөвлөсөн загварын 2 дугаар хувилбар болох “Зорчигчийн мэдээллийн төв”-д зайлшгүй ажиллах байгууллагын жагсаалтад Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Терроризмтой тэмцэх зөвлөлийг хамааруулж, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газар, Монгол банкны дэргэдэх Санхүүгийн

					мэдээллийн алба ажиллахаар тогтож, “Зорчигчийн мэдээллийн төв”-ийн бүтэц, орон тооны төсөөллийг боловсрууллаа. “Техникийн дэд ажлын хэсэг”-ийн гишүүд 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр НҮБ-ын “Golearn” сургалтын платформоор хөтөлбөртэй холбоотой сургалтад цахим хэлбэрээр хамрагдаж, сертификат гардсан. “Техникийн дэд ажлын хэсэг”-ийн талуудын оролцоо болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр, тоног төхөөрөмжийн үнийн судалгаанд аж ахуйн нэгжээс судалсан сервер, сторижийн үнийн саналыг 10 дугаар сарын 19-ний өдөр тус тус Терроризмтой тэмцэх зөвлөлд хүргүүлэв. “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд “Ажлын хэсэг”-ээс тусгах саналыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/2053 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.
2.2.	Гадаадын иргэний бүртгэлийг цахимаар хийх боломж бүхий системийг хөгжүүлэх ажлын хүрээнд бие хүний хурууны хээ, био мэдээллээр бүртгэх болон ухаалаг утас, мессеж бүртгэлийн программыг ашиглах	Программ нэвтрүүлсэн эсэх	0	1	Гадаадын иргэнийг 48 цагийн дотор гар утаснаас бүртгэх бүртгэлийн аппликейшнийг хөгжүүлж, программ хангамжийн эхний хувилбарыг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр play store-т, 09 дүгээр сарын 30-ны өдөр APP.store-т нэвтрүүлсэн. Ингэснээр гадаадын иргэнийг бүртгүүлэх ухаалаг утасны программ хангамжийг iOS, Android үйлдлийн системд нэвтрүүлснээр гадаадын

					иргэнийг орон байраар хангасан гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 48 цагийн дотор цахимаар бүртгүүлэх боломж бүрдсэн. Системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээс хойш нийт 66833 гадаадын иргэнийг дараах байдлаар бүртгэжээ. - гар утасны аппликэйшнээр – 17671 иргэн, - eimmigration.mn системээр – 44568 иргэн, - emongolia порталаар – 4594 иргэн. Программ хангамж хөгжүүлэх зах зээлийн өртөг өссөн, батлагдсан төсөв бодит өртөгтэй нийцэхгүйн улмаас “Мэдээлэл технологийн үйлчилгээний багц” 2 дугаар бүхий 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээ (мессеж бүртгэлийн)-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарласан. Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргаас тус тендерийг дахин үнэлэх тухай 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 6-1/1472 дугаар албан бичгээр чиглэл ирүүлсэн боловч төсвийн тодотголоор дээрх төсөв хасагдсан тул тус тендерийг цуцалсан байна.
2.3.	Монгол Улсын визийг цахимаар олгох	“eVisa.mn”цахим системийн нэмэлт	0	1	Цахим визийн “evisa.mn” системийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлж, 4 ангиллын визийг цахимаар олгож эхэлсэн. Тус системд 2023 онд хятад хэлний сонголт, 2024 онд WeChat төлбөр тооцооны системийг шинээр нэмэх хөгжүүлэлтийг хийв. Evisa.mn систем үйл ажиллагаанд нэвтэрснээр 2021, 2022 онуудад 36 улсын 7899, 2023 онд 45 улсын 30231, 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 77 улсын 86802, нийт 118

						улсын давхардсан тоогоор 124932 гадаадын иргэнд цахим виз олгожээ. Цахимаар 4 ангиллын виз олгож байгааг 64 буюу бүх ангилал болгож нэмэгдүүлэхээр холбогдох журамд өөрчлөлт оруулж, уригчтай 54 ангиллын визийг цахимаар олгох хөгжүүлэлтийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системд хийсэн. Тус визийн хүсэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс хүлээн авч эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 17 улсын 284 иргэнд цахим виз олгосон байна.
2.4.	Визийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн сантай холбох	Визийн мэдээллийн нэгдсэн сан бий болгосон эсэх	0	4		“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлэн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Эрээн, Шанхай, Хөх хотод суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр холбож, байгууллагаас гадаадын иргэнд олгосон визийн зөвшөөрлийг системд хандан харах эрх нээж өгсөн. Түүнчлэн 11 дүгээр сарын 18-ны өдөр нэмэлтээр 32 элчин сайдын яам, 10 консулын газар, 4 төлөөлөгчийн газарт хандах эрх нээж өгснөөр нийт 50 Дипломат төлөөлөгчийн газрыг системд холбоод байна.
Зургаа. Архивын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх						
Зорилт 1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
1.1.	Архивын ерөнхий газрын шинэ цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник	Хэрэгжилтийн хувь	0	100		Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын

	хэрэгслийн сайжруулах	хяналтыг				тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл"-ийн Монгол Улсын Сангийн яам, БНСУ-ын Экспорт-Импорт банктай хамтран 2019 -2024 онд хэрэгжүүлж бүрэн дуусгасан.Төсөл нь нийт 6 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд үүнд, ОУ-ын стандартад нийцсэн Цахим бүртгэлийн үйлчилгээ, хадгалалт болон удирдлагын системийг хөгжүүлэх", "Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах", "Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын холбогдох засвар үйлчилгээ", "Архивын баримтын хадгалалтын орчныг сайжруулах", "Цахим архивын төв", "Чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа" гэсэн 6 бүрэлдэхүүн, чиглэлүүдээр нийт 18 багц ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тус төсөл 100 хувь хэрэгжиж дууссан бөгөөд төслийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хааж, хэрэгжүүлэгч байгууллага хүлээн авсан.
1.2.	Цахим архив, албан хэрэг хөтлөлтийг хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	100		"Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл"-ийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Төрийн архивын нэгдсэн www.e-document.gov.mn системд Үндэсний төв архивд хөмрөг үүсгэгч 1299 байгууллагын мэдээллийг бүртгэсэн. Төрийн архивын https://e-document.gov.mn системд төрийн архивууд 1491 хөмрөгийн 2507 данс, бүртгэлийн 264142 хадгаламжийн нэгж, 4575,568 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн, бүртгэсэн байна. Төрийн архивын лавлагаа, үйлчилгээний https://e-archives.gov.mn системд Үндэсний төв

					архив болон 21 аймгийн төрийн архивууд 104752 захиалга шийдвэрлэж, 8,879 зөвлөгөө мэдээллийг системд бүртгэсэн. Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх (тусгай зөвшөөрөл)-ийг https://e-business.mn платформоор хуулийн этгээд үйлчилгээ авах хүсэлтээ онлайнаар гаргах боломжийг бүрдүүлж зорилт, арга хэмжээг 100 хувь гүйцэтгэж ажилласан.
Зорилт 2. Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.					
2.1.	Архивын салбарт хамтран ажиллах Орос-Монголын Засгийн газрын хоорондын хамтарсан комиссын ээлжит хуралдааныг Монгол Улсад зохион байгуулах, ОХУ-д болох хуралдаанд оролцох	Хуралдааныг зохион байгуулсан болон хуралдаанд оролцсон тоо /давтамж/	1 удаа	2 удаа	“Архивын салбарт хамтран ажиллах Монгол, Оросын хамтарсан комисс”-ын 25, 26, 27 дугаар хуралдааныг 2021-2024 онд Монгол Улсад 2, ОХУ-ын Санкт-Петербургт 1, нийт 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор Монголын талаас 29 төлөөлөгч, ОХУ-ын талаас 22 төлөөлөгч оролцсон. Тус хуралдаануудын Хамтарсан комиссын шугамаар хэвлэгдсэн Москва хотноо хэвлэгдсэн “Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн харилцаа” (1955-1985), “БНМАУ ба ЗХУ-ын хоорондох улс төрийн харилцаа” (1953-1964), “БНМАУ ЭЗХТЗ-д Евразийн эдийн засгийн интеграцчилалд хүрэх замд” (1962-1991), Монгол Улсад хэвлэгдсэн: “ХХ зууны Монгол-Оросын харилцааны түүхэнд холбогдох архивын шинэ баримт, эх сурвалж”, “Архивын салбарт хамтран ажиллах Монгол, Оросын хамтарсан комисс-30 жил” баримт бичгийн эмхэтгэл зэрэг номын нээлтийг зохион байгуулсан. Мөн УБТЗ-ын түүхийг харуулсан түүх-баримт бичгийн үзэсгэлэн, Халхын голын үйл явдлын 80 жилийн ойд зориулсан «Орос-Монголын

					харилцаа. XIX зууны хоёрдугаар хагасаас-XX зууны эх» сэдэвт түүх-баримтын хамтарсан үзэсгэлэнг зохион байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын «Улаанбаатар төмөр зам» ХНН, «Оросын төмөр замууд» ХНН-ийн дэмжлэг туслалцаатайгаар Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн «Улаанбаатар төмөр зам» нийгэмлэг байгуулагдсаны 75 жилийн ойд зориулсан баримт бичгийн эмхэтгэл зэргийг хамтран бэлтгэж хэвлүүлсэн. Санкт-Петербург хотноо болсон үзэсгэлэнг ОХУ-ын зүгээс Монгол Улс үзэсгэлэнгийн бэлтгэл, зохион байгуулалтыг өндөр түвшинд гүйцэтгэж, дорвитой ажил хийснийг онцлон тэмдэглэсэн байна.
2.2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх	Гадаад улсын ижил төрлийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн тоо	5	9	Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяа Төрийн архивын ерөнхий газартай Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Г.Мөнхбаяр 2022 оны 09 дүгээр 29-ний өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсныг хүлээн авч, баталгаажуулсан. Унгар Улсын Үндэсний архивын газартай 2022 оны 12 дугаар 12-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, баталгаажуулсан. БНХАУ-ын Үндэсний архивын удирдах газраас 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Долон нуурын гэрээ болон Монгол Улсын түүх, соёлд холбогдох хятад хэл дээрх 867 ширхэг баримтын жагсаалтыг орчуулж, Архивын ерөнхий газрын дэргэдэх Эрдэм шинжилгээний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

					2023 оны 11 дүгээр сарын 28-аас 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд БНХАУ-д зохион байгуулагдсан ОУАЗЗАБСЗ (EASTICA)-ийн ээлжит хуралдааны үеэр БНХАУ-ын Үндэсний архивын удирдах газрын дарга Ван Шаозун танилцуулж, хамтын ажиллагааны талаар уулзалт хийсэн. Казакстан Улсын Ерөнхийлөгчийн архиваас санаачлан Олон улсын архивын зөвлөл болон Алмата хот дахь Юнескогийн бүс нутгийн төв салбарын дэмжлэгтэйгээр Казакстаны Гадаад хэргийн яам, Казакстаны Соёл мэдээллийн яамтай хамтран 2024 оны 10 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд зохион байгуулсан “Нийгмийн тогтвортой хөгжлийн замд-соёлын өвийн байгууллагууд” сэдэвт Казакстаны архивчдын II конгресст Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын дарга Б.Цэндсүрэн “Монгол Улсын архивын байгууллагын бодлого, зорилт, хэтийн төлөв” сэдвээр мэдээлэл хийж оролцсон. Олон улсын архивын зөвлөлийн Зүүн Азийн бүсийн салбар зөвлөл (EASTICA)-ийн Удирдах зөвлөлийн 35 дугаар хурал “Архивын шинэ эрин үе: сорилт ба боломжууд” сэдэвт 17 дахь удаагийн Зөвлөгөөн семинар Япон улсын Токио хотод 11 дүгээр сарын 11-нээс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Монголын талыг төлөөлж 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон бөгөөд семинарт Архивын ерөнхий газрын Сургалт, судалгааны газрын дарга Ч.Оюунчимэг “Монголын архивын хөгжлийн шинэ үе: Боломж ба сорилт” илтгэл тавьж оролцсон.
--	--	--	--	--	---

2.3.	Монгол Улсын үндэсний түүх, соёлд холбогдох, гадаад улсад байгаа архивын баримтыг судалж, илрүүлэх, шилжүүлж авах ажлыг зохион байгуулах	Шилжүүлж авсан баримтын тоо	7	8	ОХУ-ын холбооны архивын агентлагтай хамтран ажиллаж хуулбарлан авах баримтын судалгаа, баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийсэн.Үүнд: Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Санкт-Петербург дэх салбарын архиваас “Д.Г.Миссершмидтийн баримтын өв: Монгол, Төвөд толь бичиг”, ОХУ-ын ШУА-ийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй сансар судлалын түүхэн хөгжил, олон улсын сансрын хамтарсан нислэгт холбогдох баримт, ОХУ-ын болон БНПУ-ын архивтай хамтран БНПУ-ын Эртний баримт бичгийн үндсэн архивд хадгалагдаж буй Алтан Ордны Улсын Тохтамыш хаанаас Польшийн хаан, Литвийн хунтайж Владислав Ягеллод 1392 онд бичсэн захидлын хуулбар, ОХУ-ын төрийн архиваас уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн түүхэнд холбогдох баримтын хуулбар, ХБНГУ-ын Гадаад хэргийн яамны Улс төрийн архивын газарт хадгалагдаж байгаа “Монгол Улсаас Герман Улсад 1925 онд анх суралцахаар явсан хүүхдүүдийн виз мэдүүлсэн багш, сурагчдын хувийн гаралтай баримт, Улаанбаатар төмөр замын 75 жилийн ойд зориулан хамтарсан комиссын шугамаар ОХУ-ын Холбооны архивын агентлагаас “Найрамдлын замаар” сэдэвт архивын баримт, ОХУ-ын Орос Улсын цэргийн төв архив, Оросын Кино, гэрэл зургийн төв архив, Эдийн засгийн төв архиваас тус тус баримт шилжүүлэн авах ажлыг зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан.
Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.					

3.1.	Гадаад оронд хадгалагдаж байгаа Монгол Улсын түүхэнд холбогдох баримтын судалгаагхийж, Үндэсний төв архивын сан хөмрөгт шилжүүлэн авах	Баримт хүлээн авсан баримтын тоо	2	8	БНХАУ-ын түүхийн нэгдүгээр архивын сан хөмрөгөөс 114 хуудас 2 баримтыг хуулбараар, ОХУ-ын холбооны архивын агентлагаас 84 хадгаламжийн нэгж, Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Санкт-Петербург дэх салбарын архиваас цахимаар 1 толь бичиг, ОХУ-ын ШУА-ийн архиваас 34 баримтын 66 хуудас, 65 ширхэг гэрэл зураг, 11 эд өлгийн зүйлс, ОХУ-ын болон БНПУ-ын архиваас 25 баримтын хуулбар, ХБНГУ-ын Гадаад хэргийн яамнаас 44 баримтын 124 хуудас бүхий архивын баримт, ОХУ-ын Холбооны архивын агентлагаас 132 ширхэг 304 хуудас баримт, ОХУ-ын Орос Улсын цэргийн төв архив, Оросын Кино, гэрэл зургийн төв архив, Эдийн засгийн төв архив, Орос Улсын архиваас 798 цахим файл, 38 ширхэг гэрэл зураг, 35 баримтат кино тус тус хуулбарлан авч, Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан.
3.2.	“Монголын баримтат аман өв” төсөлд оролцсон эх сурвалжийн баримтыг хүлээн авах	Төсөлд оролцсон эх сурвалжийн баримтыг хүлээн авсан тоо	4	8	Төслийн хүрээнд Монгол Улсын төр нийгмийн зүтгэлтгүүд, Монгол Улсын баатар, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар, хөгжмийн зохиолч, БНМАУ-ын гавьяат дууч, урлаг судлаач, Соёлын гавьяат зүтгэлтэн, урлагийн гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, зохиолч, яруу найрагч, утга зохиол судлаач, ЗХУ-ын баатар, МУ-ын анхны сансрын нисэгч, Монголын бурхан шашинтны төлөөлөл зэрэг 12 аман өв тээгчдээс нийт 172 цаг 16 минутын дүрс бичлэг, яриа, аман өвийг хүлээн авч гэрэл зураг, бусад нотломж баримтуудыг хүлээн авч Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулан ажилласан. Тухайлбал, Монгол Улсын гавьяат, Хөдөлмөрийн баатар, урлаг соёл, улс төр, нийгэм, шинжлэх ухааны

					нэрт зүтгэлтэн, эрдэмтэн, доктор зэрэг 14 хүний дурсамж яриаг 38 цагийн UHD 4k форматын 3840 pixel өргөн, 2160 pixel өндрийн хэмжээтэй нягтралтай 1242 gb дүрс бичлэг, 2550x3300 нягтралтай jpeg 159ш гэрэл зураг авч, БНМАУ-ын социалист бүтээн байгуулалтын түүхэн үйл явдалд холбогдох баримтаар Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан. Тухайлбал, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар, хөгжмийн зохиолч Н.Жанцанноровоос нийт 17 удаагийн 34 цагийн бичлэг хийж, 2 танилцуулах нэвтрүүлэг, 1 контент нэвтрүүлэг 403 gb хэмжээтэй баримтаар Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулсан бөгөөд “Аман өв” контент нэвтрүүлгийг MN 25 дугаар суваг ТВ-ээр /2020.08.08-09-ний өдөр/, МҮОНРТ-ийн сувгаар олон нийтэд хүртээл болгосон. Монгол Улсын баатар, Зөвлөлт Холбоот Улсын баатар, Монгол Улсын анхны сансрын нисэгч Ж.Гүррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд асан Ц.Нямдорж нарын 30 цагийн бичлэг хийж, зөвхөн Ж.Гүррагчаагийн хувийн гаралтай баримтаар хөмрөг үүсгэж 3620 хуудас баримт хүлээн авч, Үндэсний төв архивын сан хөмрөгийг баяжуулан, баримтат нэвтрүүлэг бэлтгэсэн. Монголын баримтат аман өв төслийн оролцогчоор Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Мэнд-Ооёо 130 минут, Соёлын гавьяат зүтгэлтэн хамба лам Д.Чойжамцын 249 минутын (266 gb) ярилцлагын дүрс бичлэг, ШУ-ны гавьяат зүтгэлтэн, доктор М.Санждорж, ШУ-ны гавьяат зүтгэлтэн, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич
--	--	--	--	--	---

						Г.Чулуунбаатар нарын дүрс бичлэг 11 хадгаламжийн нэгжийн 475 минут (33.5 gb), 35 хадгаламжийн нэгж гэрэл зургийг УТА-д хүлээн авсан.
Долоо. Салбарын албан хаагчдын боловсрол, эрүүл мэнд, хүний нөөц болон бусад нийгмийн баталгааг хангах						
Зорилт 1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.						
1.1.	Дотоод хэргийн их сургуулийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах	Барилгын ажлыг эхлүүлсэн эсэх	0	1		Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэмжлэгтэйгээр Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд байрлах Хууль зүй, дотоод хэргийн яамны эзэмшилд байсан 26.2 мянган м ² газрыг Нийслэлийн засаг даргын 2022 оны А/566 дугаар шийдвэрээр сургалтын зориулалтаар Их сургуулийн эзэмшилд шилжүүлсний дагуу газар дээр баригдах 6 барилга, 1 байгууламжийн Техник, эдийн засгийн үндэслэлийг Монгол Улсын Засгийн газрын 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийлгэсэн. Тус газарт 2024 онд орон нутгийн 2.2 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгөөр “Спорт-албаны дадлага сургалтын байгууламж”-ийг барьж, ашиглалтад хүлээн авсан.
1.2.	Салбарын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	100		Дотоод хэргийн их сургууль нь 2021-2024 онд үйл ажиллагаандаа олон улсын стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлэн 2023 онд ISO 45001:2018 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар” стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, албан хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.						
2.1.	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тусламж,	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	100		Эмнэлгийн захирлын 2021 оны А/86 дугаар тушаалаар “Ухаалаг эмнэлэг 2021-2024 он” хөтөлбөрийг 4 зорилт 30 үйл ажиллагааг

	үйлчилгээнд эмнэлэг хэрэгжүүлэх	“Ухаалаг хөтөлбөр”				төлөвлөн баталж, 2021 онд 100%-тай, 2022 онд хэрэгжүүлэх 86.5%-тай биелүүлж, 2023 онд 93.2, 2024 онд 92.6%-тай хэрэгжүүлэн ажиллалаа.
Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэтрүүлнэ.						
3.1.	Гадаадын ижил төрлийн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамтран ажиллах санамж бичгийн тоо	24	32		Их сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд гадаадын 13 ижил төрлийн их дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулсан. Үүнд: 2022 онд БНСУ-ын Вүүсок их сургууль, Чамжуван эмнэлэг, Эль эмнэлэг, ОХУ-ын Дотоод хэргийн яамны харья Волгоградын академи, 2023 онд Унгар Улсын Нийтийн удирдлагын их сургууль, БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль, АРЕХ Олон улсын байгууллага, Кайст их сургууль, Чунбук их сургууль, Алс Дорнодын их сургуультай тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Мөн БНСУ-ын Вүүсок их сургуультай солилцооны хөтөлбөрийн гэрээ, 2024 онд БНСУ-ын Үсанг их сургууль, Гёнгги их сургууль, БНФУ-ын “Аз жаргалтайгаар суралцъя” академи, ОХУ-ын Доржи Банзаровын нэрэмжит Буриад Улсын их сургуультай тус тус хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулсан.
3.2.	Судлаач, багш, суралцагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Солилцоонд хамрагдсан албан хаагч, суралцагчийн тоо	6; 20	16; 30		Хэрэгжилтийн хугацаанд нийт 57 албан хаагч, 124 сонсогч суралцагчдыг солилцооны хөтөлбөрт хамруулсан. Үүнд: багш солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 онд БНСУ-ын Чангшин их сургуульд 1 албан хаагчийг зочин багшаар ажиллуулсан. 2023-2024 онд БНСУ-ын Эль эмнэлэгтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд зочин эмчээр ажиллан, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалтад Их сургуулийн 5

					албан хаагч, АНУ-ын Миссури мужийн их сургуулийн англи хэлний сургалтад Их сургуулийн 14 албан хаагч, БНТУ-ын Үндэсний цагдаагийн академитай хамтран хэрэгжүүлсэн “Шилдэг туршлага, мэдээлэл солилцох” солилцооны хөтөлбөрт 3 албан хаагч, БНСУ-ын Вүүсок их сургуулиас зохион байгуулсан “Багш нарт зориулсан зуны сургалт” солилцооны хөтөлбөрт Их сургуулийн 25 албан хаагч, ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албанаас зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч, БНФУ-ын Сэбүгийн олон улсын академи, “Аз жаргалтайгаар суралцъя” академийн англи хэлний сургалтад 8 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн 2023-2024 оны хичээлийн жилд АНУ-ын Фулбрайт англи хэлний туслах багшийн хөтөлбөрт хамрагдан 2 туслах багшийг, 2024-2025 оны хичээлийн жилд АНУ-ын Феллов хөтөлбөрт хамрагдаж англи хэлний 1 багшийг тус тус ажиллуулж байна. Сонсогч, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд тус Их сургуулиас 2021-2022 оны хичээлийн жилд БНСУ-ын Чангшин их сургуультай хамтран хэрэгжүүлж буй 2+2 хос диплом олгох хөтөлбөрт 98 сонсогч, суралцагч, БНСУ-ын Тэнгисийн цэргийн академийн “Ерөнхий цэргийн тактик” мэргэжлээр 1 сонсогч, 2023 онд БНСУ-ын Вүүсок их сургуульд солилцооны хөтөлбөрийн хүрээнд 4 суралцагч, 2023-2024 оны хичээлийн жилд Энэтхэгийн соёлын харилцааны зөвлөл (ЭСХЗ)-ийн ICCR тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан БНЭУ-ын Шинжлэн магадлахуйн үндэсний их сургуульд 15
--	--	--	--	--	--

						сонсогч, БНСВУ-ын Нийгмийн аюулгүй байдлын яамны харьяа Ардын цагдаагийн академитай хамтран хэрэгжүүлж буй солилцооны хөтөлбөрт 3 сонсогч, БНХАУ-ын Ардын нийгмийг аюулаас хамгаалах их сургуультай хамтран хэрэгжүүлж буй солилцооны хөтөлбөрт 3 сонсогчийг тус тус хамруулан суралцуулж байна. 2024 онд БНСВУ-ын Ардын цагдаагийн академиас манай Их сургуульд 3 сонсогч суралцаж төгссөн.
Зорилт 4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.						
4.1.	Их сургуулийн үйл ажиллагаанд олон улсын ISO21001:2015 чанарын менежментийн тогтолцоо болон ISO21001:2015 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	Олон улсын ISO21001:2015 чанарын менежментийн тогтолцоо болон ISO21001:2015 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн эсэх	0	1		2021 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо, 2022 онд ISO 31000:2018 “Эрсдлийн менежмент-зарчим ба заавар” стандарт, 2023 онд ISO 45001:2018 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар” стандартыг тус тус амжилттай нэвтрүүлсэн. ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны олон улсын стандарт нэвтрүүлснийг давтан баталгаажуулсан гэрчилгээг 2024 оноос 3 жилийн хугацаагаар олгосон.
4.2.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулж, JCI олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болгох	JCI олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болсон эсэх	0	1		Эмнэлгийн захирлын 2021 оны А/73 2022 оны А/03 дугаар тушаалаар Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсэг, 2022 оны А/196 дугаар тушаалаар Олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталсан.

					Олон улсын эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх явцын үнэлгээний баг тус эмнэлэг дээр 2023 оны 04 дүгээр сарын 25-29-ны өдрүүдэд үнэлгээ хийсэн. Бүгд найрамдах Казакстан улс дах төлөөллийн байгууллагын “Удирдлагын зөвлөл”-ийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрээр Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас анх удаа Олон Улсын магадлан итгэмжлэлийг эмнэлэг болж, баталгаажуулалтын гэрчилгээг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр гардаж авсан.
4.3.	Судсан дотуурх оношилгоо, эмчилгээний ангиографийн аппарат суурилуулах	Оношилгоо, эмчилгээний ангиографийн аппарат суурилуулсан эсэх	0	1	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тул Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны өдрийн А/89 дугаар тушаалаар Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний зорилт 3-ын 3.2.1-т заасан “Судсан дотуурх оношилгоо, эмчилгээний ангиографийн аппарат суурилуулах” гэх заалтыг хассан.
	Дотоод хэргийн их сургуулийн “Шинжлэх ухаан, инновацийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024” бодлогын баримт бичгийг батлан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/150 дугаар тушаалаар баталсан “Дотоод хэргийн их сургуулийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд нийцүүлэн “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын хөгжлийн хөтөлбөр /2021-2024/”-ийг баталж, 85%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал: 2022, 2023 онд Их сургуулийн захирлын тушаалаар “Инновацийн шилдэг төсөл, бүтээл

					шалгаруулах уралдаан”-ыг 2 үе шаттай зохион байгуулж, шалгаруулсан. “Гутлын мөр болон тээврийн хэрэгслийн мөрийг бэхжүүлж авахад ашиглах хашлага” бүтээлд Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/39 тоот тушаалаар 20-0003429 улсын бүртгэлийн дугаартай ашигтай загварын гэрчилгээ авсан. “Давхар эргэх байнгын шат” төслийг үйлдвэрлэлд нэвтрүүлж төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсийн гал унтраах, аврах ангид хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, Оюуны өмчийн газарт ашигтай загварын гэрчилгээг авсан.
Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, салбарын санхүүгийн чадавх, менежментийг сайжруулна.					
5.1.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, дунд хугацаанд хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн эсэх	0	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагууд хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө зэргийг шинээр болон шинэчлэн боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд: • Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах; • Албан хаагчдыг сургалтаар хангах; • Албан хаагчдыг ажлын байранд сонгон шалгаруурах; • Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, ашиглах;

					Хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангах; Мөн “Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх” үндсэн чиглэлийн хүрээнд байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нээлттэй мерит зарчмаар сонгон шалгаруулж, чадварлаг, мэргэшсэн, идэвх санаачилга, ёс зүй, бие бялдрын өв тэгш хүний нөөцийг бүрдүүлж хадгалах бодлогыг баримтлан “Соён гэгээрүүлэх ажлын заавар”, “Харах өнцөг хамгийн чухал”, “Цагтаа амжуулъя”, “Дагаж мөрдье”, “Сахилга хариуцлагыг бэхжүүлэх” аяныг зохион байгуулж ажилласан.
5.2.	Харилцааны соёл, эерэг хандлагыг төлөвшүүлэх замаар албан хаагчдыг ёс зүйг дээшлүүлэх	Ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан эсэх	0	1	Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр салбарын хэмжээнд нийт 566 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 52076 албан хаагчийг хамруулсан.
5.3.	Албан хаагчдыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтад тогтмол хамруулж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	Байгууллага бүр сургалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гаргаж, хэрэгжүүлсэн эсэх	0	1	Агентлаг, байгууллага бүр жил бүр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж ажилласан байна. Энэ хүрээнд салбарын хэмжээнд нийт 113 төрлийн урт, богино хугацааны 7537 сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 240816 албан хаагч, ажилтныг хамруулсан байна. Мөн гадаадын 52 улс оронд зохион байгуулагдсан хурал, зөвлөгөөн, сургалтад 565, дотоодын Их дээд сургууль болон бусад 761 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 1096 албан хаагчийг хамруулсан байна.

						Түүнчлэн динамик платформыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн цахим сургалтын нэгдсэн платформд 630 удаагийн шалгалт, хичээл сургалтыг байрлуулан нийт 12415 (давхардсан тоогоор 245967) алба хаагч хамрагджээ.
5.4.	Салбарын удирдах ажилтны нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх	GREEN ERP	0	1		-
5.5	Цагдаагийн инновацийн “шинжлэх ухаан-үйлдвэрлэл-үйл ажиллагаа”-ны кластерыг үүсгэн инновацийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, зардлыг хэмнэн үр ашгийг нэмэгдүүлэх	“Хяналтын нисэх хэсэг”-ийн шинэ төв байгуулагдсан эсэх	0	1		“Хяналтын нисэх баг”-ийг байгуулах зорилгоор бага оврын нисдэг тэрэг 1 ширхэгийг худалдан авах 8.0 тэрбум төгрөгийн зардлыг шийдвэрлүүлэх саналыг 2025 оны төсвийн хязгаарт тусгуулахаар 2024 оны 01/478 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн боловч улсын 2025 оны төсөв эцэслэн батлагдаагүй байна. Нисдэг тэрэг шийдвэрлэгдэх үед нисэх хэсгийг байгуулах боломжтой.
		Дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл үйлдвэрлэх нэгж байгуулагдсан эсэх	0	1		2024 оны төсөв, 2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдаагүй.
		Тусгай зориулалтын техник хэрэгслийн стандартын лаборатори байгуулагдсан эсэх	0	1		2024 оны төсөв, 2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдаагүй.

5.6	Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүргийн хэрэгжүүлэх зарим бүс дэх газрыг албаны байртай болгох	Ашиглалтад орсон албаны байрны тоо	0	2	Хойд бүс дэх газар өөрийн эзэмшлийн 600 кв.м газрыг Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт 2018 онд гэрээний дагуу шилжүүлсэн. Тус бүтээн байгуулалтыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр гүйцэтгэн 3600 кв.м талбай бүхий 6 давхар “Нэг цэгийн үйлчилгээний цогцолбор”-ыг 2023 оны 05 дугаар сард ашиглалтад оруулсан ба Хойд бүс дэх газар нь тус цогцолборын 5 давхарт 388 кв.м талбайг бүтэн, зоорины давхарт 17.4 кв.м, нийт 405.4 кв.м талбай бүхий 14 өрөө, тасалгааг эзэмшин албаны үйл ажиллагааг эрхэлж байна. Баруун бүс дэх газрын албаны байрыг шинээр барих төсвийг “2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв”-т батлуулан зохих журмын дагуу тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, 2023 онд Баруун бүс дэх газрын албаны 3 давхар 1142.61 кв.м талбай бүхий барилга нь 1, 2 дугаар давхарт албаны өрөө, 3 дугаар давхарт албан хаагчдын амьдрах орон сууцны зориулалттай байрыг ашиглалтад хүлээж авсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас тэнхимийн буцалтгүй тусламжаар баригдах Өмнөд бүс дэх газрын албаны барилгын ажлыг 2019 онд эхлүүлсэн. COVID-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас барилгын ажил түр зогссон байсан боловч үргэлжлэн 2023 оноос барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж, өнөөдрийн байдлаар гадна цэвэр, бохир, дулаан, холбоо дохиолол, цахилгаан, тохижилтын ажлууд хийгдэж дууссан.
-----	---	------------------------------------	---	---	---

						Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/1572 дугаар захирамжаар барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс томилогдож, тус комиссын У-2024/95 дугаар дүгнэлтээр Өмнөд бүс дэх газрын албаны оффис, орон сууцны зориулалттай, зоорины давхартай, нийт 990 кв.м талбайтай, инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон, гадна, дотор камержуулалттай байрыг ашиглалтад хүлээн авсан.
5.7	Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах суурь судалгаа хийх	Судалгаа хийгдсэн эсэх	0	1		Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнээс гарч хамаарахгүй болсон тул хэрэгжилт гарах боломжгүй.
5.8	Албан бичгийн хэвлэмэл хуудас болон бусад /ном, гарын авлага/ төрлийн хэвлэлийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх	Хэвлэх хуудас тоо/ширхэг	100,000	400,000		Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0288 дугаар ангид 2007 оноос хэвлэх үйлдвэр үйл ажиллагаа явуулж, Хил хамгаалах байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас, ном, гарын авлага зэргийг үйлдвэрлэж байна. Архивын ерөнхий газар нь төрийн болон төрийн бус 2446 байгууллагын захиалгаар 4293,605 ширхэг албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэвлэсэн байна. Мөн 6 төрлийн эмхэтгэл, ном 1800 ширхэг, 2 төрлийн 600 ширхэг сэтгүүлийг тус тус хэвлэн олон нийтэд хүргэсэн. Дотоод хэргийн их сургуулийн профессор, багш, судлаачид 2021 онд нэг сэдэвт бүтээл 8, гарын авлага 10, сурах бичиг 6, нийт 24 бүтээл, 2022 онд нэг сэдэвт бүтээл 9, гарын авлага 6, сурах бичиг 4, нийт 19 бүтээл, 2023 онд нэг сэдэвт бүтээл 14, гарын авлага 14, сурах бичиг 5, нийт 33 бүтээл, 2024 онд нэг сэдэвт бүтээл 7, гарын авлага 9, сурах бичиг 1, нийт 17 бүтээл эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон байна.

						Мөн Их сургуулийн 90 жилийн ойг тохиолдуулан “Дотоод хэргийн их сургуулийн профессорын эрдмийн дээжис” 120 боть бүтээл, “Түүхэн баримт бичгийн эмхэтгэл”, “Эрдмийн далайн эзэд”, “Сонсогчийн тууж” ном тус бүр 300 ширхэг, “Түүхийн альманах” ном, “Их сургуулийн түүх” ном, “Зурагт альбом” тус бүр 1200 ширхэг, “Егөөтэй дугараа” ном 900 ширхэг, “Дурсамж дурдатгал” ном 1400 ширхэгийг тус тус эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон.
5.9	Дотоод аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийж, төсөл хэрэгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын тусгай сан байгуулах	Сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн эсэх	0	1		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд 1.6 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжсэн.
		Төсөл санхүүжүүлсэн эсэх	0	4		Шүүх шинжилгээний ерөнхий газрын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажлын төлөвлөгөөг 2023 онд 8 хэсэг, 47 ажил, арга хэмжээтэйгээр, 2024 онд 8 хэсэг, 56 ажил арга хэмжээтэйгээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувь буюу 5 оноотой бүрэн хэрэгжсэн байна. Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2021 оны А/272 дугаар тушаалаар “Сургууль хөгжүүлэх сан”-г байгуулж, ажиллах журмыг баталсан. Холбогдох журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалтын орчин нөхцөл, хэрэглэгдэхүүнийг сайжруулах зэрэг 5 чиглэлээр төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэн ажиллаж байна.
5.10	Нийслэл болон орон нутаг дахь алба хаагчдыг орон сууцжуулах, амьжиргааг нь дэмжих зорилгоор орон сууц	“Алба хаагч бүрд орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	30	70		ХЗДХЯ: Салбарын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 59 албан хаагчид байрны квот олгосон.

	худалдан авахад дэмжлэг үзүүлэх				ХХЕГ: 2023 онд 5 алба хаагчид тус бүр 50.0 сая төгрөг, 2024 онд 10 алба хаагч тус бүр 40 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. ЦЕГ: Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс алба хаагчдыг орон сууцжуулах ажлын хүрээнд 55 алба хаагчид 13-20 сая төгрөгийг олгуулах ажлыг зохион байгуулсан. “Буянт шарга” ХХК-аас хэрэгжүүлж буй “Зайсан” 180 айлын орон сууцны төсөлд цагдаа, дотоодын цэргийн 177 алба хаагчдыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр хамруулан, гэрээг байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн. Мөн 110 алба хаагчийг 6%-ийн хүүтэй ипотекийн зээлд хамруулж, 100 алба хаагчид түрээслээд өмчлүүлэх орон сууцанд хамруулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. “Ахлагч бүрэлдэхүүн”-ийг хамруулах 128 айлын орон сууцыг барих ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, орон сууцны загвар зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардлагатай техникийн нөхцөлийн 75%-ийг гаргуулаад байна. ШШГЕГ: 20 албан хаагчид байрны квот, 40 ахлагч, 42 ахмад ажилтанд иж бүрэн тавилгатай “Өргөө цагаан гэр” олгосон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд баригдаж буй “Шүр”-т хотхонд 3 ахлагчийг урьдчилгаа төлбөргүй, 8
--	--	--	--	--	--

					жилийн хугацаатай хүүгүй зээлээр орон сууцанд хамруулсан. УБЕГ: Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа “Хуулийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын орон сууцны цогцолбор хороолол”-ын төсөлд 5 албан хаагчийг хамруулж, квот олгосон. АЕГ: 2020 ашиглалтад орсон ХЗДХЯ, ШШЕГ, АЕГ-ын албан хаагчдын 390 айлын орон сууцанд 46 албан хаагч, Зайсан сүлд хотхонд 14 албан хаагчид байрны квот олгосон. Мөн Хууль зүй дотоод хэргийн яамны “Албан хаагч бүрт-орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон сууцанд 2 албан хаагчийг хамруулсан. ШШЕГ: “Хуулийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын орон сууцны цогцолбор хороолол” төслийн хүрээнд нийт 15 албан хаагч, 2 ахмад ажилтанд байрны квот олгосон. 17 алба хаагчид орон сууц худалдан авах урьдчилгаа болгон тус бүр 35,000,000-40,000,000 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Мөн 5 аймгийн албан хаагчид 1-2 орон сууцыг шийдвэрлүүлэн олгож, алба хаагчдын амьдрах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажилласан. ГИХГ: Төв, орон нутаг дахь нэгжийн орон сууцны зээлтэй 12 албан хаагчид орон сууцны мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Мөн орон сууцны ипотекийн зээлтэй, байр түрээсэлдэг төв, орон нутаг дахь нэгжийн нийт 35 албан хаагчид 309,340,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй дэмжлэг олгов.
--	--	--	--	--	--

					“Хуулийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын орон сууцны цогцолбор хороолол” төслийн хүрээнд баригдсан орон сууцанд хөнгөлөлттэй төлбөрийн нөхцөлөөр 10 албан хаагч гэрээ байгуулж, 1 албан хаагчийг НОСК-ийн түрээслээд өмчлөх хэлбэрийн хөтөлбөрт хамруулсан. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 5000 кв.м газрыг шийдвэрлүүлж, 05 дугаар сард Хууль, зүй дотоод хэргийн яамтай хамтран Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 оны ерөнхий төлөвлөгөөнд Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газрын албан хаагчдын орон сууцны барилга барих арга хэмжээг тусгуулан шугам сүлжээний ажилд 4.0 тэрбум төгрөгийг Нийслэлийн төсөвт батлуулав. ДХИС: 11 албан хаагчид 440 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлж, 6 албан хаагчид байрны квот олгосон. ТТАХНЭ: Хан -Уул дүүргийн 11 дүгээр хороонд баригдаж буй “Хуулийн байгууллагын ажилтан, алба хаагчдын орон сууцны цогцолбор хороолол”-д 2 албан хаагчид байрны квот олгосон. Эмнэлгийн захирлын 2022 оны А/203 дугаар тушаалаар орон сууны урьдчилгаа 150.0 сая төгрөгийн дэмжлэгийг 10 ажилтан, албан хаагчид олгосон.
5.11	Зарим дэд салбарын үйлдвэрлэл, туслах аж ахуйг хөгжүүлэх замаар	Санхүү, үйлдвэрлэлийн бодлого боловсруулж,	0	1	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар нь Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/202 дугаар тушаалаар нэг настай (төлөг) эр хонь 50 ширхэг,

	эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх	хэрэгжүүлсэн эсэх				60,000 төгрөгийн үнэлгээтэй, нэг настай (төлөг) эм хонь 50 ширхэг, 58,000 төгрөгийн үнэлгээтэй, нэг настай (борлон) эр ямаа 50 ширхэг, 40,000 төгрөгийн үнэлгээтэй, нэг настай (борлон) эм ямаа 50 ширхэг, 42,000 мянган төгрөгийн нэг бүрийн үнэлгээтэй нийт 10,000,000 төгрөгийн үнэ бүхий 200 толгой малыг тус байгууллагад балансаас балансад шилжүүлэн авсан. Цаашид туслах аж ахуйн чиглэлээр малын үр өгөөжийг тухай бүр бүртгэж, байгууллагын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар шохойн чулуу, барилгын материал, оёдол, мод боловсруулах, төмөр хийц, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, 2020 онд туслах үйл ажиллагаанаас 3.6 тэрбум төгрөгийг 2024 онд 11.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, төсвийн ачааллыг буурсан байна. Шинээр гурил, цэргийн хувцас, төмөр хийцийн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг өргөжүүлсэн.
--	-------------------------------------	-------------------	--	--	--	---